

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр, Лхагва гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 5
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6 - 47
1.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/</i>	7
2.	<i>Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2024.02.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/</i>	8
3.	<i>“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	9 - 31
4.	<i>Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	31 - 47

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 05 дугаар сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 00 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Батлут, Ж.Ганбаатар;
Тасалсан: Ц.Даваасүрэн, Д.Өнөрболор, О.Цогтгэрэл.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 2024 оны 05 дугаар сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2024.02.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Ц.Цэрэнпунцаг: Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг

дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Нийслэлийн Засаг даргын орлогч П.Сайнзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлувсан, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Очирваань, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, мөн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга Г.Нямцэцэг, Макро эдийн засгийн бодлогын газрын Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Отгонбат, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн газрын дарга Ш.Цэрэндулам, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Г.Төгөлдөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Батмөнх, Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, М.Оюунчимэг, Б.Баттөмөр, Н.Ганибал, Т.Энхтүвшин нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Нийслэлийн Засаг даргын орлогч П.Сайнзориг, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн газрын дарга Ш.Цэрэндулам нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам үг хэлэв.

Ц.Цэрэнпунцаг: “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Эрдэнэбулган, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Д.Энхтүвшин, Улаанбаатар хотын Худалдааны танхимын Ерөнхийлөгч Д.Ончинсүрэн, Улаанбаатар хотын Худалдааны танхимын гүйцэтгэх захирал Б.Хаш-Эрдэнэ, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын гүйцэтгэх захирал Т.Дүүрэн, Бодлого, стратегийн газрын дарга Ж.Оюунчимэг, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын дарга С.Энхцэцэг, Ерөнхий нарийн бичгийн дарга М.Шинэбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Пүрэвсүрэн, Өмгөөллийн “Хэруга Партнерс” ХХН-ын гүйцэтгэх захирал, өмгөөлөгч Л.Загдаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Батмөнх, Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ч.Ундрам, Т.Энхтүвшин, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Д.Энхтүвшин, Улаанбаатар хотын Худалдааны танхимын Ерөнхийлөгч Д.Ончинсүрэн, Өмгөөллийн “Хэруга Партнерс” ХХН-ын гүйцэтгэх захирал, өмгөөлөгч Л.Загдаа нар хариулж, тайлбар хийв.

Ц.Цэрэнпунцаг: Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 51 минут үргэлжилж, 18 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувийн ирцтэйгээр 16 цаг 51 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордны “Их засаг” танхим
15 цаг 00 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Дамбын Батлут гишүүн чөлөөтэй байгаа.

Жамбалын Ганбаатар гишүүн чөлөөтэй.

Ингээд бусад нь хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 61.1 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 05 сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хороогоор хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

4 асуудал байна.

Нэгдүгээрт. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт заасны дагуу “2024 оны 05 дугаар сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хоёр. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2024 оны 02 сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Хэлэлцэх эсэх үргэлжилнэ.

Гурав. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Засгийн газар 2024 оны 04 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Хэлэлцэх эсэх.

Дөрөв. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газрын 2024 оны 04 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Хэлэлцэх эсэх гэсэн 4 асуудлыг Байнгын хороогоор хэлэлцүүлэхээр энэ долоо хоногийн хэлэлцэх асуудлын тов дараалалд оруулсан байна.

Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал нэг.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

2024 оны 05 дугаар сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын “Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 66 дугаар захирамжид заасан Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаварыг хавсралтаар баталсугай.

2.Хуульд хэлэлцэх хугацааг тусгайлан заасан асуудал болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3.Энэ тогтоолын биелэлтийг хангаж, хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын Тамгын газар Д.Энхбатад үүрэг болгосугай.

Төсөлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалт явуулж эхэлье. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 2024 оны 05 дугаар сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 66.7 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 2024 оны 05 дугаар сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа. /алх цохив/

Дараагийн асуудалдаа орёе.

Хоёр.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2024.02.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцэж эхэлье.

Хуулийн төслийг 04 дүгээр сарын 19-ний өдөр Байнгын хорооны хуралдаан хэлэлцэж эхлээд гишүүд асуулт асууж, үгээ хэлж дууссан.

Үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг дэмжих талаар санал хураалт явуулах үед хуралдааны ирц хүрэхгүй болсон тул санал хураалт явагдаагүй. Хэлэлцүүлэг зогссон.

Иймээс санал хураалтаа явуулья. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Саналын томъёололыг Та бүхэндээ уншиж танилцуулья.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд

хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 58.3 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулна.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг дууслаа.

Ажлын хэсэг гарч байж болно. Ажлын хэсэгт баярлалаа.

Хэлэлцэх асуудал гурав.

Гурав. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Төсөл санаачлагч санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар танилцуулна. Ч.Хүрэлбаатар сайдын микрофоныг нээе.

Ч.Хүрэлбаатар: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт Засгийн газар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд **“Эдийн засгийн өсөлтийн өгөөжийг өрх бүрт хүргэх”** гэсэн зорилгын хүрээнд

- “Эдийн засгийн тогтвортой өсөлтийн бодлого”,
- “Эдийн засгийн өсөлтийг өрх бүрт хүргэх хүний хөгжлийн бодлого”,
- “Шинжлэх ухаан, дэвшилтэт технологид тулгуурласан засаглалын бодлого”,
- “Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах бодлого”,
- “Ногоон хөгжлийн бодлого”,
- “Бүсчилсэн хөгжлийн бодлого”,
- “Улаанбаатар хотын бүсчлэл - 20 минутын хотын бодлого”,
- “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх”

гэсэн бодлогын **8** тэргүүлэх чиглэл, **224** төсөл, арга хэмжээнд нийтдээ **11.8** их наяд төгрөгийг санхүүжүүлэхээр тусгалаа. Үүнээс:

- улсын төсвийн хөрөнгөөр **3.9** их наяд төгрөг,
- орон нутгийн төсвийн хөрөнгөөр **0.2** их наяд төгрөг,
- гадаадын зээлээр **1.8** их наяд төгрөг,
- гадаадын тусламжаар **0.2** их наяд төгрөг,
- төр хувийн хэвшлийн түншлэлээр **2.6** их наяд төгрөг,
- хувийн хөрөнгө оруулалтаар **1.4** их наяд төгрөг,
- бусад эх үүсвэрээр **1.7** их наяд төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөлөө.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн нэрсийг танилцуулья.

Чимэдийн Хүрэлбаатар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Батгөмөрийн Энхбаяр Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гантөмөрийн Түвдэндорж Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нэргүйн Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Цогтын Баярбат Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ханджавын Батжаргал Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нямдоржийн Анхбаяр Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сандагдоржийн Батболд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чимэдцэрэнгийн Цэвэгдорж Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сандагсүрэнгийн Магнайсүрэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Батаагийн Батцэцэг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төмөрхуягийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нансалын Тавинбэх Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Пүрэвжавын Сайнзориг Нийслэлийн Засаг даргын

орлогч, Лхагвасүрэнгийн Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Даваасамбуугийн Эрдэнэбаяр Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Дэмбэрэлийн Очирваань Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга, Гантулгын Нямцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга, А.Хишигбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, С.Отгонбат Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ч.Гандирваа Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Галбадрахын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн.

Төсөл санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан

асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү?

Ч.Ундрам гишүүнээр тасаллаа.

Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: 4 л асуулт байна даа.

Нэгдүгээрт, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль Их Хурал дээр хэлэлцэгдээд явж байгаа.

Тэгээд түүнтэй холбоотойгоор дахин нөгөө рестракшн гэж ярина шүү дээ. Нөгөө хотуудаа хооронд нь хуваагаад явах гээд байх шиг байна. Түүнтэй холбоотой санхүүгийн, хөгжлийн ямар төлөвлөгөө, ямар заалт энэ төлөвлөгөөнд орсон бэ? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Энэ төрийн өмчит компаниудын өгөөжийг 4 хувьд хүргэнэ гэсэн байна л даа.

Одоо өгөөж нь хэдтэй байгаа юм? 4 хувь хүрэхээр ер нь ямар хэмжээний ногдол ашиг юм уу, татварын үр өгөөж юм уу байх юм?

Гуравт, бизнесийн хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг 4 тэрбумд хүргэнэ гэсэн байна л даа. Энэ ямар төслүүд дээр хөрөнгө оруулалт татах гэж байгаа юм гэдэг асуулт байна.

Дөрөвт, Улаанбаатар хотын нэг тулгамдсан хоёр асуудал байгаа шүү дээ. Нэг нь, шар усны хуримтлалын сан. Нөгөөдөх нь, хог дахин боловсруулахтай холбоотой хоёр төсөл яваад байдаг. Төсөв нь байхгүй гээд ерөөсөө хэрэгждэггүй.

Тэгэхээр үүнийг тэр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэмжээнд нь нөгөө юугаар хэрэгжүүлэх боломж байгаа эсэх. Тодруулах гэсэн юм аа? Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Ажлын хэсгээс 2 номер дээр очоод суу даа. Ажлын хэсгийн 2 номерын микрофоныг нэеэ дээ. Тэр хоосон суудал дээр очоод суучихад болно.

Хотын даргын орлогч
П.Сайнзориг дарга хариулья.

П.Сайнзориг: Х.Ганхуяг гишүүний асуултад хариулья.

Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль одоо хэлэлцүүлгийн шатад байгаа.

Хууль яг хэзээнээс дагаж мөрдөх асуудлыг мэдээж Улсын Их Хурал эцэслэн батална.

Засгийн газрын өргөн барьснаар Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль 2025 оны 06 сарын 01-нээс, “Хот байгуулах” Улсын Их Хурлын тогтоол нь 2026 оны 01 дүгээр сарын 01-нээс байгаа учраас энэ жилийн төлөвлөгөөтэй уялдуулж тухайлан яг энэ чиглэл рүү юм тавигдаагүй.

Тэгэхдээ мэдээж одоо энэ хотуудын болоод, бас энэ улсын хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулаад төсөл, хөтөлбөрүүд тусаад явж байгаа.

Хоёрдугаарт, таны асууж байгаа жилийн төлөвлөгөө дээр тэр хог шатаах, хогийн менежменттэй холбоотой болон тэр усны асуудалтай холбоотой

зүйлүүдийг тусгаад явах бүрэн боломжтой.

Ер нь улсын болон орон нутгийн төсвөөр гэхээсээ илүүтэй төр, хувийн хэвшлийн түншлэлээр дээрх төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж харж байгаа.

Бид ажлын хэсэг дээр үүнийг анхаараад явъя.

Ц.Цэрэнпунцаг: Х.Ганхуяг гишүүн тодруулж асууя. Нэмэлт хариулт байгаа юу? Өөр ажлын хэсгээс нэмж хариулах хүн байна уу? Байхгүй бол Х.Ганхуяг гишүүн тодруулж асууя.

Х.Ганхуяг: 4.1.1 дээр хөрөнгийн өгөөжийг 4 хувьд хүргэнэ гэсэн заалт байхгүй.

Тэгээд үүнийг би одоо хэд байдаг юм? Тэгээд 4 хувьд яаж хүрэх гэж байгаа юм гэдгийг нь асуух гэсэн юм.

Хоёрдугаарт, манайхаас ер нь бусад бүх орон гадаад харилцаа нэлээн эдийн засагжаад яваад байгаа шүү дээ.

Нэгд, эдийн засгийн харилцаа, бизнест харилцаа яваад байгаа. Энэ тал дээр ер нь Гадаад хэргийн яам цаашдаа ямар арга хэмжээ авах вэ? Манайхаас бусад бүх л орон Элчин сайдын яамдуудаа **KPI**[key performance indicator]¹-жуулаад, нөгөө экспортоо тэдэн хувьд хүргэх, хөрөнгө оруулалтыг татах гээд бүр даалгавартай, зорилттой болгочихсон байгаад байна л даа.

Тэгээд манайх тийм ажил ерөөсөө хийгдэхгүй хаягдчихаад байдаг.

Тэрийг Гадаад хэргийн яам хариуцах юм уу, Эдийн засгийн хөгжлийн яам хариуцах юм уу?

Тэгээд яаж энэ 4 тэрбум долларын гадаадын хөрөнгө оруулалтыг татах гээд байгаа юм гэдгийг л би сонирхон асуугаад байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс. Сая Х.Ганхуяг гишүүний асуусан тодруулга асуултад хэн хариулах юм? Гадаад явдлын яам хариулах уу? Н.Анхбаяр дарга аа.

Ер нь гадаадад ажиллаж байгаа энэ Элчин сайдуудад чинь ийм үүрэг даалгавар байгаа юм уу, үгүй юу? Албан үүрэг даалгаврууд өгсөн юм уу, үгүй юу гээд байна шүү дээ. Энэ улс орны эдийн засагт нь ийм ийм үр өгөөжтэй ажлууд хийж байна гээд. Байг гэхэд тайлан тавьж байгаа юм байгаа юм уу гээд асуугаад байна.

Та хариулах уу? Ч.Хүрэлбаатар сайдын микрофоныг нээе.

Ч.Хүрэлбаатар: Ер нь Монгол Улсын цаашдын хөгжилд хөрөнгө оруулалт их чухал.

Өчнөөн олон Монгол залуучууд гадаадад явж ажиллаж байгаа. Амьдарч байна.

Уг нь тэр гадаадад очиж нэг үйлдвэрт ажиллаж байснаас тэр үйлдвэрийг нь Монголд оруулаад ирвэл их зөв байгаа юм. Ийм учраас энэ Хөрөнгө оруулалтын хуулийг дэмжээд явуулах тухай асуудлыг би Эдийн засгийн байнгын хороон дээр дахиж ярьж байна.

¹ **KPI** –“Гүйцэтгэлийн гол шалгуур үзүүлэлт” гэдэг нь бизнесийн тодорхой зорилгод хүрэх, ахиц дэвшлийг хянахад ашиглагдах тоон үзүүлэлт.

Засгийн газар татаагүй байгаа. Тэр хуулийг. Хэн нэгэн хүн буцаагаагүй байгаа. Их Хурлын гишүүд кнопдож байж тэрийг шийдвэрлэнэ.

Тийм учраас энэ хөрөнгө оруулалтын хуулийг дэмжиж байж цаашаа явна гэдгийг би дахиж энд хэлмээр байна.

Хоёрдугаарт нь, Элчин сайдын яамдыг хөрөнгө оруулалт татахаар юу хийж байгааг сайн хэлж мэдэхгүй юм байна.

Яагаад вэ гэхээр Эдийн засаг, хөгжлийн яам уг нь гадаадад тэр эдийн засгийн асуудлыг, хөрөнгө оруулалтыг татахыг хичээж чармайж ажилладаг. Дэмжих энэ чиглэлийн хүмүүсийг Эдийн засаг, хөгжлийн яаманд хэдэн жил ажилласан хүмүүсүүдээ явуулаад байвал Эдийн засаг, хөгжлийн яамтайгаа холбогдоод энэ чиглэлийн бодлого нь зөв явж байх юм.

Одоо бол энэ чиглэлийн ажил хийгддэггүй учраас би хэлж мэдэхгүй юм байна.

Тийм учраас одоогоор Элчин сайдын яамдаас гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, ер нь хөрөнгө оруулалтыг Монголд оруулж ирэх урсгалыг нэмэгдүүлж байгаа ажил байхгүй гэж хэлэхэд нэг их буруудахгүй болов уу гэж бодож байгаа.

Дараа нь тэр **“Return on Assets”**² дээр байгаа. Тэр бол ийм юм байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын жилийн эцсийн тайлангаар 2023 оны байдлаар 3.5 хувьтай байгаа юм байна. Үүнийг 0.5 хувиар өсгөх ийм

зорилт тавьж оруулж ирж байгаа юм байна. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Х.Ганхуяг гишүүн хариултаа авсан уу? Болчихсон уу? М.Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Энэ Байгаль орчны яамнаас Төрийн нарийн бичгийн дарга нь байсан уу? Байна уу? Тийм ээ.

Би нэг асуулт асууя. Эхлээд “байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүрээнд байгаль орчны гүйцэтгэлийн индексийг 150-д хүргэнэ” гээд 5.1.

5.2 дээр нь “эко системийн үзүүлэлтийг 70 хувьд хүргэнэ” гэж байна. Тэгээд энэ хойд талыг нь харсан чинь ой бүрхэгдсэн талбай, эзлэх хувийг томсгоно гээд нэг том л юм ярьчихсан байна. Яг бодит байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалт гэхээр.

Энэ дээр жишээ нь хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр асуудал тусгагдаж байгаа юу. Яагаад гэвэл одоо жишээ нь нийслэл Улаанбаатар хотод гэхэд хөрсний бохирдлын хувь хэмжээ 98 хувьд хүрчихсэн. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж хүртэл гарчихсан. Ноцтой байдалд гээд.

Сая жишээ нь нүхэн жорлонгоос өгсүүлээд халдварт өвчин тараадаг ийм зүйл байна гээд хөрсний бохирдлын хувьд бид гамшгийн түвшинд улаан гэрэл асчихсан байна л даа.

Тэгэхээр яг энэ 2024 онд энэ 5.1, 5.2 заалтын хүрээнд хөрсний бохирдлыг бууруулахтай холбоотой ямар асуудал тусгагдсан бэ гэдэгт нэгдүгээрт хариулт авъя.

² **Return on Assets** - “Хөрөнгийн өгөөж” гэдэг нь компани хэр ашиг олж болохыг харуулах ашгийн харьцаа.

Хоёрт нь, Байгаль орчны яам. Би бас хэлээд л байгаа. 4 тэрбум төгрөгийг тусгаад нийслэлийн хөрсний бохирдлыг бууруулахын тулд тэр эко жорлон байршуулна гэж хэлээд жишээлбэл манай Чингэлтэй дүүргийн 19, 7 гэдэг хороодод хэд хэдэн нүх ухаад хаячихсан.

Одоо үүнийгээ дуусгахгүй бол энэ чинь өөрөө асуудал үүсгээд бидний маш сайн явж байгаа төслийг андууруулах хэмжээнд улс төржих асуудал ч гарахыг үгүйсгэхгүй байна.

Та энэ дээр маш тодорхой хариулт өгөөч?

Одоо орчны бохирдлыг бууруулах газар нь нэг хэсэг Эрчим хүчний сайд дээр байсан чинь одоо нийслэлд гэсэн. Одоо хаана очоод байгаа юм бүү мэд. Энхбат гэдэг дарга нь хаана юу хийж байна бүү мэд. Энэ дээр нэг хариулт өгөөч. Үүнийг хэзээ дуусгах вэ? Хэнтэй энэ асуудлыг? Бид хугацаатай үүрэг даалгавар өгөөд энэ дээр та нарыг хянахгүй бол энэ чинь болохгүй болоод байна. Тэр мөнгийг ингэж салхинд хийсгэж болохгүй.

Тэгээд энэ дээр нэгд хариулт өгнө үү гэж хэлмээр байна.

Хоёрт нь, ер нь энэ хөрсний бохирдлыг бууруулахтай холбоотой төслүүдээ маш хурдан явуулмаар байна. Энэ салбарын яамд нь.

Гуравт нь, түрүүн бас хэллээ. Нийслэл Улаанбаатар хотын төлөвлөлттэй холбоотой Эдийн засгийн хөгжлийн сайд хариулах уу, эсвэл Нийслэл Улаанбаатар хотоос маань хүмүүс байгаа. Хариулах уу?

Одоо Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль нөгөө “20 минутын хот” гээд бид ард иргэддээ хэдийнээ мэдээллүүд өгөөд үүнийг бас хүмүүс их хүсэн хүлээж байна.

Юу хүлээж байна гэхээр гэр хорооллын төлөвлөлт нэг юм явах нь. Одоо хэсэгчилсэн инженерийн дэд бүтцийн хүрээнд гэр хорооллын төлөвлөлт явах нь.

Байшин хороолол, тэр дундаа жишээлбэл 40, 50 мянгат, одоо энэ Бага тойруу гээд яриад байгаа. Энэ дээр байшингууд нь 60 жилийн насжилттай болоод, одоо бүр нурж унахад бэлэн. Тэгээд энэ байшингийн засвар үйлчилгээ гэхээр СӨХ_[сууц өмчлөгчдийн холбоо] нь өөрөө дийлэхгүй. Хувь хүмүүс нь өөрсдөө санхүүжилтээ гаргаад хийх боломжгүй.

Тэгэхээр төр энэ чинь бас нийтийн эзэмшлийн талбай гэдэг утгаараа улсын төсөв, олон улсын санхүүжилтээр энэ засвар үйлчилгээ хийхэд нь тусална гэдэг заалт байдаг юм байна шүү дээ.

Тэгээд энэ дээр ямар арга хэмжээ авах вэ? Тэгээд энэ чинь өөрөө одоо Улаанбаатар хотын яг энэ Бага тойруу, 40, 50 мянгатыг харахад хүн гишгэх битгий хэл хүмүүс хүүхдээ ч салхилуулах газаргүй болчихсон. Яагаад гэхээр иргэд нь өөрөө машин тавих ч газар алга. Шамбааралдаад, шамбааралдуулаад. Дундуур нь ингээд жижиг жижиг дэлгүүр ч юм шиг, лангуу мангуу ингээд барьчихсан.

Тэгээд эд нарыг нураах гэхээр хувийн өмчид халдсан гээд. Гэтэл нийтийн эзэмшлийн талбай.

Зарим нь бүр одоо ашигладаггүй 14, 15 жил болчихсон, балгас болчихсон.

Тэнд нь хүний амь, хүчирхийллийн гэмт хэргүүд хүртэл гараад байгаа гээд. Тэгээд ийм байшингууд жишээлбэл энд зөндөө байна. Одоо жишээ нь Чингэлтэйн Соёл урлагийн их сургуулийн ар тал бол бүр битүү болчихсон. Та нар маань ч өөрсдөө явж байгаа байх. Ингээд нэг чиглэл болоод машин хоорондоо зөрөх боломжгүй нил түгжрэл болчихсон нэг ийм байгаад байгаа.

Тэгэхээр 2024 онд энэ төлөвлөлтийн хүрээнд яг үүнтэй холбоотой санхүүжилт тусгагдах уу, олон улсын санхүүгийн босгох санхүүжилт байгаа юу? Үүнийг яаж төлөвлөж байгаа вэ гэсэн хоёр асуултад хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: Байгаль орчны яамнаас төлөөлж ирсэн хэн билээ? Нэрээ хэлээд хариулаарай. 2 номер.

Ш.Цэрэндулам: М.Оюунчимэг гишүүний асуултад хариулья. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн Газрын дарга Ш.Цэрэндулам байна.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажил бол Засгийн газрын шийдвэрээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар дээр харьяалагдан ажиллаж байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, бид хөрсний бохирдолтой холбоотой асуудал дээр нэгдсэн судалгааг хийсэн. Та сая хэлж байна. Хөрсний бохирдол үнэхээр хүндрэлтэй нөхцөл байдалтай байгаа. Тийм. Хүндрэлтэй нөхцөл байдалтай байгаа.

Энэ асуудал дээр 2019 оноос эхлээд Байгаль орчин, аялал жуулчлалын

яамнаас “Ногоон зээлийн бодлого”-ыг барьж эхэлж авч хэрэгжүүлээд явж байна.

Энэ хүрээнд 2024 онд ногоон зээлийн хүүгийн татаас дэмжлэг дээр 1.5 тэрбумыг тавьсан байж байгаа. Энэ хүрээнд нийтдээ 3 банкаар дамжуулагдаад иргэн 6 хувийн хувийн хүүтэй зээл, харин аж ахуйн нэгж, байгууллагад 8 хувийн хүүтэй зээлийг олгох ийм боломж бололцоог бүрдүүлсэн.

Нэг талаасаа энэ хөрсний бохирдлыг бууруулах үйл ажиллагаанд улсын тус төсөв болон олон улсын байгууллагын дэмжлэг туслалцаатайгаар ажилладаг.

Улсын төсвийн хүрээнд тодорхой хэмжээгээр төслүүд гэдэг юм уу. Тийм ээ. Хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн. Эдгээр маань тухайн иргэний хашаанд гэдэг юм уу даа, тухайн иргэний тодорхой амьдралын чанарыг дээшлүүлэх чиглэлээр ажиллаж байгаа учраас иргэн өөрөө хариуцлагагүй байх иймэрхүү нөхцөл байдлууд бий болсон.

Үүнтэй уялдуулаад ногоон зээлийг аль болох дэмжих ийм чиглэл байр суурийг хэрэгжүүлээд явж байна.

Зөвхөн яамнаас хэрэгжүүлж байгаа улсын төсвийн хүрээнд хүүгийн дотациас гадна олон улсын байгууллагууд, банк, санхүүгийн байгууллагууд ногоон зээлийг нэлээн сайн идэвхтэй дэмжин хэрэгжүүлж байна. Хамгийн сүүлд Европын сэргээн босголтын банк, Уур амьсгалын Ногоон сангийн санхүүжилтээр ногоон зээлийг бас ингээд нэлээн том хөрөнгө оруулалтыг татаад ингээд аваад ажиллаж байна.

Тэр нолийн хувьд Эрдэнэтэд хийгдсэн 1 тэрбумын нолийн асуудал гэж би ойлгоод байгаа. Мянган өрхөд хийгдэж байгаа.

Хотод хийгдсэн нолийн хувьд Барилга, хот байгуулалтын яам. Тийм. Барилга, хот байгуулалтын яам хариулсан нь зүйтэй байх гэж бодож байна.

Яагаад вэ гэхээр хөрөнгө нь тэдний дээр тавигдаж, зарцуулалт нь тэдний дээр хийгдсэн учраас. Манай дээр тавигдсан хөрөнгө оруулалт 1 тэрбумынхаа хүрээнд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны зохион байгуулалттайгаар Эрдэнэт хотын мянган өрхөд хийгдсэн ийм ажил байгаа.

Одоогийн байдлаар гүйцэтгэл 97 хувьтай гэсэн. Гэсэн хэдий боловч бас иргэдийн хувьд нэлээн сэтгэл ханамжгүй байгаа ийм нөхцөл байдлууд үүсэж байгаа. Учир нь юу вэ гэхээрээ зэрэг тендер шалгарсан компани хариуцлагагүй ажиллах иймэрхүү нөхцөл байдлууд байгаа юм. Тийм.

Ц.Цэрэнпунцаг: М.Оюунчимэг гишүүний асуусан асуултад Улаанбаатар хотоос байгаа. П.Сайнзориг дарга нэг хариулчих. Дараа нь дахиад Барилга, хот байгуулалтын яам бас хариулах шаардлагатай байна шүү. Бэлдэж байгаарай. 2 номер дээр П.Сайнзориг дарга хариулъя.

П.Сайнзориг: П.Сайнзориг байна. Хөрсний бохирдолтой холбоотой бас яах вэ нэмж хариулъя.

Ер нь Улаанбаатар хотоос уг асуудлыг дэд төвүүдийн хөгжүүлэлтийг сайн хийх. Ийшээ нэгэнт хөрөнгө оруулалт хийгдсэн. Сэлбэ, Баянхошуу

дэд төвөөс орон сууцжуулах бодлогыг барьж байна.

Бид хэд энэ жилийн хувьд 20 мянган айлын орон сууцыг барьж байгуулах ажлыг гадаадын бонд босгох замаар “Сэлбэ дэд төв”-ийн бүтээн байгуулалтыг хийнэ.

Энэ дээрээс шийдэж чадвал орчны болон агаарын бохирдол, дээрээс нь дан замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулахад нэлээдгүй ахиц авчирна гэж байгаа.

Чөлөөлөгдөж байгаа 158 мянган га дээр баригдах 12 мянган орон сууцаас 10 мянган илүү гарч байгаа орон сууцыг бид Чингэлтэй, Хайлааст, Дэнжийн мянга, 5 буудал ч гэдэг юм уу, энэ орчмын айлуудыг нүүлгэн шилжүүлж оруулах.

Ингэснээрээ үндсэндээ 24 сарын хугацаанд дахин 701 га газрыг чөлөөлж авах юм бол хотын яг хоймор хэсэг болох энэ хэсгийг үндсэндээ хөрсний бохирдол, орчны бохирдлыг байхгүй болгох, сэргийлэх энэ бололцоог бүрдүүлж чадна гэж бид үзэж байгаа.

Ийм байдалтай орон сууцжуулах бодлогыг бас нэлээн дэмжиж ажиллах ийм байдалтай байгаа.

Хотын төв төвийн энэ ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцын асуудал дээр төвөгтэй юм бий.

Одоо яг ингээд дахин төлөвлөлтийг хувийн хэвшилд нь өгчихье гэхээр маш өндөр орон сууц барих сонирхолтой. Яагаад гэхээр ашгаа хийхийн тулд. Ингээд өндөр орон сууцыг барьчихаар хажуу хавийн хүмүүс нь дургүйцдэг. Эргээд хотын түгжрэл дээр нэмэлт юу гэдэг юм орц гарцаасаа эхлээд

хүндрэлтэй нөхцөл байдал үүсчхэж байгаа юм.

Яг тэр намхан байдлаар нь юм уу, 3, 4 давхраар нь дахин төлөвлөлтийн ажлыг хийчихье гэхээр орж ирэх компани байхгүй, ашиггүй гэдэг байдлаар ингээд ийм зүйлүүд байгаа.

Хоёрдугаарт, бид хэд энэ дахин төлөвлөлтийн ажил сүүлийн арваад жил асуудлуудаа бүрэн шийдэж чадаагүй байгаа. Үнэн. Бараг энэ хохирчхоод байгаа 600 иргэнээс 200-ыг нь л бид цэгцлээд, одоо 200-аад иргэн бас байна. Яагаад гэхээр аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанаас шалтгаална.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: П.Сайнзориг дарга та гүйцээгээд хариулчихъя.

П.Сайнзориг: Тэгэхээр энэ яах вэ, яг тендерт орж ирээд авчхаж байгаа юм. Компаниуд маань. Тэгж байтал хөрөнгөө босгож чаддаггүй, иргэдтэйгээ үл ойлголцдог. Иргэд нь ингээд хоёр хуваагддаг ч юм уу, төслийг явуулахгүй байдалтай болчхож байгаа маш олон энэ дахин төлөвлөлтийн төслүүд нийслэл дээр байгаа.

Бид эдгээрийг бас учрыг нь олчих гээд бас нэлээдгүй явж байна. Эргээд энэ бас тодорхой компаниудын хариуцлагагүй юм бий. Манай нийслэлтэй ч холбоотой албан хаагчдын ашиг сонирхлын ч юмнууд гарч байгаа. Бид бас холбогдох хууль хяналтын байгууллагад өгөөд явж байгаа.

40, 50 мянгатын орчмын энэ байруудыг газар хөдлөлтийн тэсвэрлэх байдлыг нь бас Барилга, хот байгуулалтын яамнаас үнэлсэн. Нурахад

бэлэн байгаа. Ерөнхийдөө маш эрсдэлтэй байгаа. Үүнийг яах аргагүй дахин төлөвлөлтөд оруулах ийм зайлшгүй шаардлага байгаа.

Тэгэхээр бид хэд бас ямар ч байсан энэ замын хөдөлгөөний түгжрэл бүх юмтай уялдуулж бас энэ дахин төлөвлөлтийн асуудлыг шийдэхгүйгээс хэт хэт өндөршилттэй барилгуудыг хотын төвөөр зөвшөөрөөд байх дахин төлөвлөлтийн хувьд бас боломжгүй байгаа.

Тэгээд энэ дээр бас Нийслэлийн орон сууцын корпорацыг боломжит байдлаар төслийг хэрэгжүүлэх ийм төлөвлөлттэй зарим ажлуудыг ингээд төлөвлөөд явж байгаа гэдгийг танд хэлье.

Ц.Цэрэнпунцаг: Барилга, хот байгуулалтын яамныхан байна уу? Хариулчхаарай. Очоод тэр 2 номер дээр. Ажлын хэсгийн 2 номер дээр сууж байгаад хариулчих. Ажлын хэсгийн 2 номерыг нэе.

Ц.Баярбат: Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат.

М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Ер нь Чингэлтэй дүүрэг дээр нийтдээ яг энэ “Ногоон хороо”, “Эко хороо”-той холбоотой, “Жишиг гудамж”-тай холбоотой 3 төсөл арга хэмжээг 2022, 2023 онуудад хөрөнгө оруулалтууд нь тавигдсан.

2022 онооноос эхэлж тавигдсан байгаа. Тухайлбал, “Ногоон хороо” хөрөнгө оруулалт 2022 онд 4 тэрбум,

2023 онд шилжих байдлаар 4 тэрбум бас тавигдаад ингээд хийгдсэн.

“Жишиг гудамж” тохижилт төслийн хувьд бас ялгаагүй 2022 онд хөрөнгө оруулалт нь 3 тэрбум, 2024 онд 900 сая төгрөг шилжихээр тавигдаад ингээд ажлууд нь хийгдээд явж байна.

Ер нь төрийн хэмнэлтийн хуультай холбоотойгоор шинэ хөрөнгө оруулалтуудыг 2023, 2024 онд нэмж тусгаагүй байгаа.

Ц.Цэрэнпунцаг: М.Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

М.Оюунчимэг: 2024 оны төсөвт хөрсний бохирдлыг бууруулахтай холбоотой хөрөнгө оруулалт тусгагдсан байгаа шүү. Та бүхэн маань эндэх ажлаа бас хурдасгаарай гэж хэлмээр байна.

Байгаль орчны яам яагаад асуудлаас бултаад байна вэ, Ш.Цэрэндулам дарга аа.

Энэ Барилга, хот байгуулалтын яамтай ямар ч хамаагүй. Б.Бат-Эрдэнэ сайд өөрөө энэ Туул голын орчим буюу Хан-Уул, Чингэлтэй дүүргийн хөрсний бохирдлыг бууруулах зориулалттайгаар 4 тэрбумд суусан. Нэгийг нь ямар ч зориулалтгүйгээр Эрдэнэт рүү шилжүүлсэн.

Харин тэр хотод хийж байгаа нолиудаа зүгээр нэг эхлүүлээд ухаад хаяад явчихсан. Одоо тэнд хүүхэд явж байгаад унасан тохиолдол гарсан.

Үүнийгээ та Б.Бат-Эрдэнэ сайдад хэлээрэй.

Ажлаа дуусгахгүй бол төсвийн мөнгийг зориулалтын бусаар ашигласан

гээд Эрдэнэттэй холбоотой асуудлыг нь ярина шүү гэдгийг дамжуулаарай. Тэгээд ажлаа дуусгаарай. Хөөе.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд нэмж хариулья.

Ч.Хүрэлбаатар: М.Оюунчимэг гишүүний зарим асуултуудад хариулья.

Ялангуяа энэ хөрсний бохирдолтой холбоотой асуудал байгаа. Тэгээд энэ дээр нөгөө та бүгд энэ жилийн төлөвлөгөөг үзсэн байгаа байх. Үзэж байгаа байх.

Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж байгаа дэд бүтцийн төслүүд байдаг. Дэд төвүүдийн.

Ингээд Азийн хөгжлийн банкнаас 10 жилийн хугацаатай 3 үе шаттай төсөл хэрэгжиж байгаа.

Хоёрдугаар үе шат нь Дамбадаржаа, Дэнжийн мянгын төвд нийтдээ 121 сая ам.долларын зээлээр 150 хүүхдийн цэцэрлэг, 650 хүний суудалтай спорт цогцолбор, 126 айлын орон сууц, мэдээлэл, үйлчилгээний төв, 18.7 километр цахилгаан, дулааны шугам, 63 мегаваттын дулааны станц, олон нийтийн хөгжлийн үйлчилгээний төв гээд 4.4 километр авто зам.

Мөн Европын Холбооны банкны 19.64 сая ам.долларын зээлийн хүрээнд 11.7 километр цэвэр усны хоолой, 10.2 километр бохир усны хоолой, 5 километр үерийн хамгаалалтыг энэ хоёрдугаар үе шатдаа хийх юм.

Гуравдугаар шатад нь яг иймэрхүү ижил төслийг Шар хад, Толгойтод хийнэ. Бас нийт санхүүжилтийн зүүн дүн нь 114.2 сая доллар байгаа.

Тэгэхээр ерөнхийдөө ер нь л энэ дэд төвүүдийг байгуулах замаар хөрсний бохирдлыг цэгцлэх, дэд төвүүдийг байгуулах замаар цаашдаа гэр хорооллуудын дэд бүтцийн асуудлуудаа шийдэх энэ зам бол ер нь зөв зам байх гэж бодож байгаа учраас энд хоёр төслүүдийн хэрэгжилт дээр онцгой анхаарал тавьж байгаа юм гэдгийг хэлье.

Тэгээд жилийн төлөвлөгөөндөө оруулсан.

Төслийн нэгдүгээр шатад та бүгд санаж байгаа Сэлбэ, Баянхошуу дэд төвүүд гээд нийтдээ 318 га газарт дэд төвүүдийг орчныг нь бүрдүүлсэн байгаа гэдгийг хэлье.

Ц.Цэрэнпунцаг: Б.Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, хүлээгдэж байгаа гүйцэтгэл ямар байгаа вэ? Ч.Хүрэлбаатар сайд.

Миний ойлгож байгаагаар 32 асуудал. Би ажлын хэсгийг нь ахалж хөгжлийн төлөвлөгөөг батлуулсан учраас сайн санаж байна.

32 асуудал 2024 оны төсөвт суугаагүй.

Тэгэхээр тэр гадна дотнын зээл, тусламж, хувийн хэвшлээрээ ямархуу байдалтай явж байгаа юм бэ? Үүнийг нэгдүгээрт асууя гэж.

Хоёрдугаарт, 68 их наяд төгрөгийн жагсаалт санал ирсэн юм байна.

Яг энэ дээр хэдийг нь оруулж ирж байгаа вэ гэсэн хоёр дахь ийм асуулт байна.

Гурав дахь асуудал бол яах вэ энэ дотор “Оюу Толгой” төсөл далд уурхайн ашиглалтад орж үр ашиг нэмэгдэнэ л гэж байгаа юм. “Оюу Толгой” төсөл тэр тогтвортой байдлын гэрээндээ 4 жил тутамд техник, эдийн засгийн үндэслэлээ батлуулах ёстой.

Одоо аваад явж байгаа арга хэмжээний хүрээнд аваад үзэхээр хөрөнгө оруулалтын хэмжээгээ 1.6 тэрбум доллароор нэмэгдүүлнэ. Баяжмалд байгаа алтны хэмжээг 20 тонноор багасгана. Зэсийн баяжмалынх нь зэсийн агуулгыг 1.2 сая тонноор багасгана гэсэн 4 жилийн техник, эдийн засгийн үндэслэлүүд нь тийм юм явж байхыг нь би харсан. Тэгэхдээ тэр батлагдаагүй байх л даа.

Тэгэхээр Оюу Толгойтой ер нь Засгийн газрын зүгээс яаж ажиллаж байна аа? Улсын Их Хурлаас 92 дугаар тогтоол гаргаад Засгийн газар тодорхой чиглэлүүд өгчихсөн байгаа. Биелсэн гээд хаачихсан. Ялангуяа тэр баяжмал дотор байж байгаа агуулга, тэр бусад элементүүдийн тэр агуулгыг тодорхой болгоё, лаборатори байгуулъя, хөндлөнгийн аудит оруулъя, татварын маргааныг шийдье. Зөндөө олон асуудал биелэгдээгүй байхад нь хаасан л даа.

Тэгээд Оюу Толгойтой ер нь ямар хэмжээнд ажиллаж байна аа? Татварын маргаан гэхэд л 2025 оны 9 сард 1.3 их наяд төгрөгийн татварын асуудал Лондонгийн шүүх дээр яригдана гэж байгаа юм. Жил бараг хагасын дараа.

Тэгэхээр бид болохоор энэ төлөвлөгөөндөө Оюу Толгой гүний

уурхай ашиглалтад орно, их сайн болно л гээд байдаг. Тэгээд энэ ер нь өгөөж нь ямар байх юм бэ гэсэн ийм юм байна.

68 их наяд төгрөгөөс одоо яах вэ, бид улсын төсвөөр нэг жилд 3.5 их наяд төгрөг л төсвөөсөө гаргаж хөрөнгө оруулалтдаа зардаг шүү дээ.

Тэгэхээр одоо яг хэд болсон? Улсын төсвөөр хэд хийх вэ? Хувийн хэвшлээр хэд хийх вэ? Гадаадын хөрөнгө оруулалтаар хэд хийх вэ гэсэн нэг ийм асуулт байна.

Дараагийн асуудал, энэ нүүрсний үнийн асуудал байгаа юм. Өнгөрсөн жил 70 сая тонн нүүрс гаргаад 43 хувиар өссөн. Өнгөрсөн жилийнхээс. Төсөвт орох мөнгөний хэмжээ 1.5 дахин нэмэгдсэн сайн үзүүлэлт.

Гэхдээ бид Оросын Холбооны Улсаас нийлүүлж байгаа нүүрснээс 20 хувиар, цаад талын Индонезийн нийлүүлж байгаа нүүрснээс бараг 50-иад хувиар хямд нийлүүлж байгаа шүү дээ.

Асар их нөөцтэй учраас хямд үнийн бодлого бариад байгаа юу, эсвэл бидний ер нь байж байгаа нь энэ юм уу? Энэ бүс нутгийн зах зээлийн үнэд хүргэж худалдах чиглэлээр ямар ажил хийх гэж байна гэж.

Төгсгөлийн асуудал. Энэ дотор явж байсан. Энэ тэргүүлэх чиглэлд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 5 хувь болгож бууруулна гэж. Татварын шинэчлэлээр бид чинь Монголын нийт татвар төлөгчдийн 93 хувь нь 1 хувийн татвар төлөгч шүү дээ.

Аж ахуйн нэгжийнхээ орлогын албан татвартай ингэж оролдох ёстой юм уу, эсвэл тэр нийгмийн даатгалын

шимтгэл, хувь хүний орлогын албан татвар эд нар дээрээ шинжилгээ, судалгаа хийх ёстой юм биш үү?

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Б.Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Одоогоор 2024 оны гүйцэтгэл ер нь хэр байгаа гэж. Ер нь нэлээд шахаад ажиллаж байна.

Ер нь энэ 2024 оны биелэлт ер нь их гайгүй гарчих болов уу гэсэн байдалтай явж байгаа гэдгийг би хэлье. Тал талдаа л хичээгээд л шахаад л ажиллаж байгаа гэдгээ би нэгдүгээрт нь хэлмээр байна.

Ер нь энэ 2024 оны жилийн төлөвлөгөөний гол. Та зөв анхаарсан байна.

Ер нь л экспортыг дэмжье, хөрөнгө оруулалтыг дэмжье гэдэг ийм л бодлого оруулж ирж явж байгаа.

Яг өнөөдрийн байдлаар Монгол Улс 24 сая тонн нүүрс экспортолчихсон байна.

2023 онд Монгол Улс чинь бараг 70 сая тонн нүүрс экспортолсон шүү дээ.

Тэгэхэд эхний 04 сарын байдлаар 19 саяыг л гаргаж байсан. Одоо 24 сая гэдэг чинь харьцангуй өнгөрсөн жилээсээ сайн ийм байгаа.

Нүүрснийхээ үнийг бидний хувьд биржээр тогтоодог болоод явж байгаа. Хуучин “Эрдэнэс Тавантолгой” гэдэг компанийн захирал үнээ тогтоодог. “Эрдэнэс Тавантолгой” гэдэг

компанийн захирал ямар компанитай хэчнээн хэмжээний нүүрс борлуулах вэ гэрээ хийдэг вэ гэдгээ тогтоодог байсан бол одоо компанийн захирал биш бирж дээр цэвэр өрсөлдөөний дүн дээр үнэ тогтоож байгаа.

“Эрдэнэс Тавантолгой” компанийн сонгож авсан компанитай нь гэрээ байгуулдаг биш бирж дээр хамгийн өндөр үнэ өгсөн компанитай нь нүүрс борлуулах гэрээ хийж байгаа.

Тэгэхээр тал талдаа нэлээд ахиц дэвшил гарсан. Ингээд биржийн хуулийг баталж өгсөн энэ Байнгын хорооны гишүүддээ талархаж байгаагаа илэрхийлье.

Үндсэндээ энэ биржээр уурхайн бүтээгдэхүүнүүдийг зарж эхэлснээс хойш тэнд байгаа ялзралууд бүгд алга болсон, ил тод болсон. Хамгийн гол нь борлуулалт сайжрахаас гадна дагаад тээвэрлэлт гаргаж байгаа хэмжээ хүртэл эрс сайжраад явчхаж байгаа.

Тэгэхээр уурхайн салбар дээр байгаа энэ ил тод байдал, өрсөлдөөнийг хангах, тэгээд хамгийн өндөр үнэ өгсөн, санал өгсөн компанитай нь гэрээ хийдэг энэ тогтолцоо руу шилжсэн энэ зүйл ихээхэн дэвшил авчирсан гэдгийг би энд онцолж хэлмээр байна.

Зэсийн гаралт мөн ялгаагүй нэлээн сайн байгаа. Өнгөрсөн жил өдийд 400 мянган тонн зэсийн баяжмал гарч байсан бол одоо 500 мянган тонн гарч байна.

Ер нь 2024 оны эдийн засгийн нөхцөл байдал 2023 оныхоосоо илүү байхаар харагдаж байгаа гэдгийг бид хэлье.

Ер нь тэгээд энэ экспортоо дэмжиж байж, хөрөнгө оруулалтыг дэмжиж байж Монгол Улс хөгжинө гэдэг нь ойлгомжтой болж байна гэдгийг л хэлье. Баярлалаа. Заримыг нь орхигдуулсан байх.

Ц.Цэрэнпунцаг: Гүйцээж хэн яриад байгаа юм? Б.Баттөмөр гишүүн яг аль асуултаар нь.

Оюу Толгойтой холбоотой тодорхой асуултууд асуусан. Уул уурхайн яамнаас байна уу? Ажлын хэсгийн 2 номерын микрофоныг нэе. Нэрээ хэлж танилцуулаад хариулаарай.

М.Мэндбаяр: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр.

“Оюу Толгой” ордын нөөц болон үр ашгийн тухай Б.Баттөмөр гишүүн асуулаа. Асуултад хариулья.

Өнөөдрийн байдлаар Засгийн газар дээр байгуулагдсан Ажлын хэсгээс гадна “Оюу Толгой” ордын шинэчилсэн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулагдаж орж ирсэн.

Тэгээд Б.Баттөмөр гишүүний түрүүн хэлсэн тоонууд бас түүн дээр зарим тоонууд нь байсан тоонуудыг дурдаж байх шиг байна.

Өнөөдрийн байдлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар байгуулагдсан шинжээчийн ажлын хэсэг байгуулагдчихсан. ТЭЗҮ-д шинжээчдийн ажлын хэсэг ажиллаж байгаа.

Тэгээд тэр шинжээчдийн ажлын хэсэг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэхэд бэлтгэж байна

гэсэн үг. Процессынхоо хувьд. Тэгээд хурлаар орохын өмнө шинжээчдийн эцсийн үнэлгээгээр хэдий хэмжээний нөөцийг нэмэгдүүлэх вэ, бууруулахаар байна уу, өсгөхөөр байна уу, хэдийг нь буруу тооцсон байна гэдэг бүх залруулгууд нь хийгдсэний дараа Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэгдээд тэгээд нөөц болон эдийн засгийн үзүүлэлтүүд нь эцэслэгдэж гарч ирэх юм.

Ц.Цэрэнпунцаг: Б.Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Энэ төлөвлөгөөнд энэ эрүүл мэндийн салбарын бас юмнууд байж л байна.

Тэгэхдээ энэ одоо үндсэндээ Монголын энэ ядуурлын хавх гэдэг юмыг чинь эрүүл мэндийн салбар бас оруулчихсан байгаа шүү дээ. Өвчтэй хүмүүс бүх юмаа зараад тэгээд очоод өвчнөө эмчлүүлж чаддаггүй тэгээд хавханд ордог.

Тийм учраас энд нэг эрт илрүүлэлт гэсэн ганц нэг юм байна. Тэгээд энэ хорт хавдрын өвчлөлөөр дэлхийд тэргүүлж байгаа, нас баралтаар тэргүүлж байгаа.

Тэгээд энэ дээр энэ шинжлэх ухаан, технологийн ололт Монголд нутагшуулах барих энэ чиглэлийн юмнууд байхгүй л байх шиг байх юм. Яах вэ орон сууцад сая баялгийн сангаар 10 мянган айлын орон сууцын эх үүсвэр ингээд орчихлоо. Эрүүл байж байж орон сууцад орно шүү дээ. Тийм ээ.

Тийм учраас энэ дээр учир дутагдалтай байгаа юм биш үү. Үүнийг цаашдаа хэлэлцэх явц дунд эрүүл мэндийн салбарын юмыг анхаарвал яасан юм бэ гэсэн ийм юм байна.

Тэр аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр хариулт авсангүй.

Ц.Цэрэнпунцаг: Татвартай холбоотой асуултад хариулт авсангүй гэж байна. Сангийн яамнаас байгаа юм уу?

М.Санжаадорж. Ажлын хэсгийн 2 номерын микрофоныг нээе.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж.

Б.Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Тийм. Үнэхээр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувьд манай улсын нийт аж ахуйн нэгжүүдийн 93 хувь маань 1 хувийн татвартай байгаа.

Энэ нь өөрөө орлогын хэмжээнээсээ шалтгаалаад 1.5 тэрбумаас доош, мөн инновацын байгууллагууд нэртэйгээ явчхаж байгаа.

5 хувьтай болгох асуудал энэ баримт бичиг дээр байхгүй.

Бид ачааллын хувьд татварын ачааллыг үзэхэд татварын ачаалал бусад улсуудтай харьцуулахад боломжийн хэмжээнд гарч байгаа.

Татвараас гадна шимтгэлийн асуудал тусдаа асуудал байдаг. Нийгмийн даатгалын шимтгэл эргээд тухайн ажилтан, алба ажил хийж байгаа тэр иргэндээ хүрэхэд чиглэсэн, зориулсан байдаг.

Нийгмийн даатгалын сан маань өөрөө 4 сангаас бүрддэг.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах буюу тухайн иргэн осол мэргэжлийн шалтгаалсан өвчинд бол, эсвэл ажилгүйдлийн даатгалын сан, эсвэл тэтгэвэрт гарах юм бол гээд эргээд энэ маань иргэнд зориулсан ийм зүйл байдаг.

Нийгэмд нийгмийн даатгалын шимтгэлийг татвар мэтээр ойлгож, үүнийг хольж ярьдаг зүйл байдаг.

Хувь хүний орлогын албан татварын хувьд манай улс өөрөө 10-ын системээр явдаг. Хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар гээд.

Хувь хүний орлогын албан татвар өөрөө дээр нь орон нутгийн орлого байдаг. Тодорхой хэлэх юм бол сум, дүүргийн орлого байдаг. Энэ нь өөрөө сум, дүүргийнхээ хувьд орлогын гол эх үүсвэр байдаг учраас бид бас үүнийг бууруулах талаар одоогийн байдлаар татварыг бид өөрчлөх талаар ямар нэгэн тийм чиглэл байхгүй.

Ер нь татвартай холбоотой шинэчлэлүүдээ бид хийчихсэн. Татварын шинэчлэлүүд маань сүүлд хийгдээд дууссан.

Ц.Цэрэнпунцаг: Б.Баттөмөр гишүүн нэмэлт асуулт асууя.

Б.Баттөмөр: М.Санжаадорж оо, энэ 6.1.3 дээр энэ бүсийн тэргүүлэх чиглэлд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 5 хувь болгоно гээд байна.

Би эсвэл буруу юм хараад байна уу? Энэ дээр байж л байх юм. Тэр нийгмийн даатгал яах вэ дээ.

Ер нь би нөгөө ачааллын хувьд л ярьж байгаа шүү дээ. Тийм ээ. Хувь

хүний орлогын албан татвар, нийгмийн даатгал, тэр шимтгэл хоёр дээр ажил олгогчдын зүгээс асар их асуудал тавьдаг.

Би наад татварын шинэчлэлийн чинь ажлын хэсгийн ахлах нь би шүү дээ. Тийм ээ.

Тийм учраас маш сайн мэдэж байгаа. Тэгээд энэ хоёрыг л ярьсан юм л даа.

Чи энэ 6.1.3 дээр үзээдэхдээ. Байж байна.

Ц.Цэрэнпунцаг: М.Санжаадорж хариулъя. Ажлын хэсгийн 2 номерыг нээе.

М.Санжаадорж: Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулаад татварын хөнгөлөлтийн асуудлыг бүс бүс дээр тухайн бизнесийн орчинтой нь уялдуулаад тухайн бүсийн онцлогт тохируулсан байдлаар хөнгөлөлт үзүүлэх талаар яригдаж байгаа.

Түрүүний 1 хувийн ачаалалтай байгаа гэдэг 1 хувийн татвартай гэсэн үг биш. Аж ахуйн нэгж 10 хувийн татвар хэвээрээ байж байгаа.

Зүгээр бид хөнгөлөлт үзүүлж байгаа асуудал байгаа. Яг үүнтэй ижилхнээр бүсүүдэд жишээ нь төвийн бүс дээр бид газар тариалан, аж үйлдвэр илүү чухал гэж үзэх юм бол энэ хэсэг дээр бид хөнгөлөлт үзүүлэх агуулгаар энэ заалтыг оруулсан.

Тэгэхээр ачаалал гэдэг байдлаар энэ заалтаа тодотгож оруулбал илүү зөв болох юм байна гэж бид хэд харж байна. Тийм.

Түүнээс биш үндсэн татварын системийг бид хэд эвдэхгүй. Б.Баттөмөр гишүүн ээ. Тийм. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Н.Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Яамны олон дарга нар байгаа дээр нэг ганц нэг асуулт асуучихъя.

Та хэд маань Монгол даяараа **“Шинэ хоршоо”** гээд л бараг яам болгоноос хүмүүс яваад байгаа биз дээ. Тэр гол асуудлаа яагаад энэ дээрээ бичихгүй байгаа юм бэ?

2025 онд хэдэн хоршоо байгуулагдах юм? Ямар ямар асуудлуудыг шийдэх юм?

Бараг өнөөдрийн нийт 176 төслөөс чинь илүү хөрөнгө оруулалттай байна шүү дээ. 5 их наядын хөрөнгө оруулалт Монголын мал аж ахуй руу хийнэ гээд ингээд дайрч довтлоод явж байгаа.

Тэгээд үр дүн гэдэг юмаа энэ дээрээ төлөвлөхгүй юм уу? Аягүй бол Хөдөө аж ахуйн Төрийн нарийн чинь үүнийг мэдэхгүй байх л даа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хүн байна уу?

Засгийн газар маань ер нь жоохон ажил үүргийнхээ хуваарийг зөв хийхгүй бол ингээд нэг ийм хаа хамаагүй байдлаар асуудалд ханддаг энэ юм бас жоохон хэрээс хэтэрч байна.

Хэрэглэх газрын сайд нь загвар хоршоо танилцуулаад явдаг. Тэгээд эдийн засгийн тооцоолол үндэслэл муутай. Нөгөөдөх нь ашиггүй. Асуудлыг яг юуг нь шийдэх гээд байгаагаа

тодорхой бус. Зүгээр зээл өгнө гээд ийм байдлаар салбарын асуудал руу орж байгаа нь аягүй харамсалтай байгаа шүү.

Хөдөө аж ахуйн Төрийн нарийн байгаа дээр.

Энэ цэцэг өвчний чинь вакцин яагаад өнөөдөр хүртэл хөдөө орон нутгууддаа очихгүй байгаа юм бэ? Та хэд маань олон сайхан юм төлөвлөсөн л байна. Тэгээд яг бодит амьдрал дээр маш энгийн үйлдлүүд чинь дэндүү их орхигдоод байна. Үүнийг та нэг хариулаад өгөөч?

Ер нь төлөвлөгөө гарснаас хойш 2 жил болж байна л даа. Тэгээд 2023 оны төлөвлөгөөний биелэлт маань ер нь хэдэн хувьтай байгаа вэ?

Ер нь бид бүхэн энэ дээрээ ер нь цаашид Эдийн засгийн сайдаас асуухад яг ийм төлөвлөлт гаргаад явах нь хууль дээрээ байгаа ч гэсэн бид нарт ер нь зөв юм уу?

Яг бодож байгаа төлөвлөсөн юмнаасаа дандаа л өөр өөр шинэ юм гаргаж байж л бид чинь хийж яваад байна л даа. Том их хөрөнгө оруулалтуудын асуудлууд, том шийдвэрүүд нь

Тэгэхээр ингэж үүнийг ингээд нэг ийм төсөвтэй уялдсан төлөвлөгөө гаргаад, тэрийг хэлэлцээд, тэгээд нэг батлаад, тэрнийх нь хэрэгжилт нь хэдэн хувь байсан ч хамаагүй явж л байдаг. Нэг ийм ерөнхий байдлаар явах нь зөв үү гэж би бас тодруулж асуумаар байна.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд хариулах уу? Тэгье.

Т.Жамбалцэрэн дарга хэдэн номер дээр сууж байна. 2 номер дээр очёе. Ажлын хэсгийн 2 номерыг нэе.

Т.Жамбалцэрэн: Н.Ганибал гишүүний асуултад хариулья.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсан.

Өнгөрсөн өвөл хавар амаргүй өвөл, хавар болсон.

Энэ хаврын байдлаар 7.5 сая толгой мал өнөөдрийн байдлаар хорогдчихсон. 5 мянга гаруй айл өрх ямар нэгэн байдлаар мал сүргээ 70 хувиас дээш алдчихсан. Мянга гаруй айл ямар ч малгүй болчихсон ийм нөхцөл байдалтай байгаа.

Нөгөө талаараа **“Хүнсний хангамж, аюулгүй байдал”** үндэсний хөдөлгөөн Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол хэрэгжээд явж байгаа. Тэгээд яг энэ асуудлууд дээр улбаалаад Монгол Улсын Засгийн газраас **“Цагаан алт”** хөтөлбөрийг Улсын Их Хуралд өргөн барихаар бэлтгээд, Ерөнхийлөгч санаачлаад явж байгаа.

Тэгээд эдгээр асуудлуудтай уялдаад явахаар яалт ч үгүй малчдын нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх, малчдынхаа амьжиргааг дэмжих, байгаль, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх ийм тулгамдсан шаардлага бий болж байгаа.

Нөгөө талаараа малаас гарч байгаа малын гаралтай түүхий эд,

бүтээгдэхүүний чанар, хөдөлмөрөө хоршиж нийлэх зохион байгуулалтын ажил үнэхээр тулгамдаж байгаа асуудал байгаа.

Тэгээд энэ үүднээс түүрүүн дурдсан хууль, Монгол Улсын Засгийн газрын тогтоол гарч энэ **“Шинэ хоршоо”** хөдөлгөөнийг өрнүүлэх шийдвэр гарсан.

Нэг талдаа “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хэрэгжилт сүүлийн жил гаруй хугацаанд нэлээд сайн үр дүнтэй. Жилдээ бид 1 тэрбум ам.долларын хүнсний бүтээгдэхүүн импортоор авдаг байсан бол өнгөрсөн оны жилийн эцсийн дүнгээр бид 880.0 сая ам.долларын хүнсний бүтээгдэхүүнийг импортоор авсан ийм дүн мэдээтэй байгаа юм.

Эргээд түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн асуудал яриад ирэхээр манай мал аж ахуйн салбараас бэлтгэгдэж байгаа бүтээгдэхүүн нь доголдолд орчхож байгаа.

Өнөөдөр бид жилдээ 10 мянган тонн ноолуур бэлтгэдэг байсан бол энэ жил 8500 тонн л ноолуур бэлдэж байгаа.

Энэ хэмжээгээр малчдын орлого буурах, хөдөө аж ахуйн салбар дээр хамгийн үнэтэй гэдэг **“Цагаан алт”** болсон бүтээгдэхүүн нь хомсдоод ирэхээр экспорт, импортын гадаад худалдаан дээр ч гэсэн асуудал үүсээд явж байгаа.

Эдгээр асуудлуудыг цогцоор нь шийдэх зорилгоор **“Шинэ хоршоо”** хөдөлгөөн өрнөж байгаа.

Тэгээд энэ жилийн тухайд арилжааны банкнуудын эх үүсвэрээр 500 тэрбум орчим төгрөгийн эх үүсвэр

арилжааны банкнудаас гарах бололцоотой гээд 8 арилжааны банктай гэрээ байгуулаад ажиллаж байгаа.

Энэ хоршоо хөдөлгөөн амжилттай хэрэгжих юм бол бидний өмнөх Улсын Их Хурлаас баталсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, “Хүнсний хангамж аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, “Цагаан алт” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бас үр дүнтэй суурь нь болж өгөх юм гэсэн энэ агуулгаараа энэ хоршоо хөдөлгөөнийг хэрэгжүүлээд ажиллаж байгаа.

Тэгээд энэ чиглэлээр орон нутгуудад бас тодорхой ажлын хэсэг гаргаад хоршоо байгуулах чиглэлээр.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Энэ “**Шинэ хоршоо**” жилийн төлөвлөгөөнд байхгүй биш байгаа.

Эдийн засгийн тогтвортой өсөлтийн бодлого гээд 1 дүгээр хэсэг дотор “**Шинэ хоршоо**” хөтөлбөр өөрөө байгаа юм.

Яагаад вэ гэхээр цаг агаарын өөрчлөлттэй холбоотой хөдөө аж ахуйн салбар байнга уналтад явж байгаа.

Тэгээд энэ цаг агаарын эрсдэл, байгалийн эрсдэлийн хүчинд 200 гаруй мянган малчин өрх тус тусдаа юм хийх гэж гүйж яваад үр дүнд хүрэх үү, эсвэл хамтарч ажиллах чиглэлээр явах нь дээр үү гэдэг ийм ажлууд байгаа.

Тэгээд “**Шинэ хоршоо**” сайн дураараа. Хүн хоршихыг хүсэхгүй байгаа

бол тусдаа явж болно. Нээлттэй шүү дээ гэдгийг би хэлмээр байна.

Тэгээд энэ жилийн төлөвлөгөөний нэгдүгээрх чиглэлд орсон тэр “**Эдийн засгийн тогтвортой өсөлтийн бодлого**” дотор “**Шинэ хоршоо**” хөдөлгөөнийг үндэсний хэмжээнд өрнүүлнэ гэсэн тэр заалтынхаа хүрээнд байгаа гэдгийг хэлье.

2023 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг 79.2 хувийн биелэлттэй гэдгийг тайлагнасан. Өмнө нь.

Тэгэхээр энэ хувь нь байгаа гэдгийг хэлье.

Ц.Цэрэнпунцаг: Н.Ганибал гишүүн хариултаа авсан уу? Т.Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа.

Энэ “**Ногоон хөгжлийн бодлого**”-ыг хэрэгжүүлнэ гээд ийм заалт орсон байна л даа.

Тэгээд энэ нөгөө “**Хөх морьт**”, “**Хэрлэн-тооно**”, “**Орхон-Онги**” төсөл гээд энэ чинь ер нь хэрэгжих юм уу, хэрэгжихгүй юм уу?

Тэгээд үүнийг нь үзэхээр ерөөсөө л нэг энэ ойгоор бүрхсэн талбайг 100 хувьд хүргэнэ, ургамлын гарцыг нэмэгдүүлнэ, усны нөөцийн хуримтлалыг нэмэгдүүлнэ, газрын доройтлын арилгана гээд л нэг ийм л юм орчхоод байх юм.

Тэгээд энэ говьд чинь цөлжилт явагдаж байна. Шар шороон шуурганы нүүдэл явагдаж байна. Нөгөө гүний усны хомсдол явж байна.

Тэгээд говьд ер нь цаашдаа энэ газар тариалан эрхлэх, мал аж ахуй эрхлэх ийм бололцоо боломж аягүй хүнд болж байна л даа.

Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан нөгөө тэрбум модны асуудал чинь л зогсчоод байгаа шүү дээ. Усны асуудлаас болоод.

Тэгээд энэ “Хөх морь” төслөө ер нь хэрэгжүүлэх юм уу, хэрэгжүүлэхгүй юм уу? Яагаад энд орсонгүй вэ? Нөгөө эдийн засгийн тогтвортой байдлыг хангая л гэж бодож байгаа бол усны асуудлыг л говь руу татахгүй бол цаашдаа бидний яриад байдаг нөгөө боловсруулах болон баяжуулах үйлдвэр маш олон иргэдийг ажилтай, орлоготой байлгах асуудал гээд энэ бүх зүйлүүд чинь хаагдах юм байна. Хаагдах юм байна.

Сая Дундговь, Өмнөговийн нутгаар явж байхад ерөөсөө л ярьж байгаа асуудал усны асуудал байна.

200, 300 метр өрөмдөөд ус гарахгүй байна. Юун мод услах манатай. Одоо бараг нэг модыг ургуулах гэж 4, 5 сая төгрөгийн ус хэрэглэх юм байна гэдэг ийм л асуудал ярьж байна шүү дээ.

Тэгээд Байгаль орчны яам яагаад энэ асуудлыг оруулж ирсэнгүй вэ? Яагаад энэ говь руу ус татах асуудал, цаашдаа энэ говьд юу байдаг юм уулын баялаг нь байж байна.

Энэ баялгаа эдийн засгийн эргэлтэд оруулаад үнэтэй болгох асуудал, дээр олон хүнийг ажилтай, орлоготой болгох асуудал дээр яагаад үүнийг Байгаль орчны яам оруулж ирсэнгүй вэ?

Хоёрдугаар асуудал, энэ ногоон эдийн засгийг бий болгоё, ногоон эрчим хүчийг бий болгоё гээд л яриад байдаг.

Тэгээд яг нидэр дээрээ Монгол улсад сэргээгдэх эрчим хүч барьчих юм бол Монгол Улсад хохиролтой, үнэ тариф нь өндөр гээд үндсэндээ бариулдаггүй юм билээ шүү дээ.

Тэгээд манай Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон энэ төсвийн төсөл, төсөөлөл дээр дандаа л “ногоон эдийн засгийг бий болгоно” гэдэг үг нь байгаад байдаг.

Тэгээд энэ Сэргээгдэх эрчим хүчнийхээ тухай хуулийг өөрчлөөд энэ үнэ тарифын асуудлыг нь багасгаж болдоггүй юм уу? Цаасан дээр лоозон хэлбэрээр явмааргүй байна.

Тэгээд энэ асуудал дээр Байгаль орчны яам нэг жоохон санаачилгатай ажилламаар байна.

Усны асуудал байх юм бол эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж бид чадна. Усны асуудлыг. Одоо энэ гүний усны асуудал багасаад тэгээд хуурайшилт явагдаад байна шүү дээ.

Тэгээд бидний нөгөө яриад байдаг өндөр үнэтэй бүтээгдэхүүнээ заръя, үйлдвэр байгуулья, олон хүн ажлын байраар хангая гээд. Энэ юм чинь ингээд эсрэгээрээ яваад байгаа учраас энэ дээр Байгаль орчны яам жоохон санаачилга дутаад байгаа юм биш үү.

Энэ 4 жилийн хугацаанд харж байхад ерөөсөө энэ Онги, Орхон голын асуудлыг огт ярьсангүй. Хэрлэн-Тоонын асуудлыг Байгаль орчны яам огт ярьсангүй.

Цаашдаа говьд үүсээд байгаа энэ эрсдэлүүдээ бид яах юм бэ? Яваандаа ер нь хүнгүй Ыолгоё гэж бодож байгаа юм уу? Тэгээд энэ усны асуудлаа яаж шийдэх гээд байгаа юм? Яагаад энд оруулсангүй вэ? Энд нэг жижигхэн жижигхэн зүйлүүд л оруулчихсан байна л даа. Энэ дээрээ нэг Байгаль орчны яам нэг тодорхой хариултыг хэлж өгөөч.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 2 номерын микрофоныг нээе.

Ш.Цэрэндулам: Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн газрын дарга Ш.Цэрэндулам.

Т.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Энэ жилийн улсын хөгжлийн төлөвлөгөөний хувьд 5.2.3.1 дээр тусгагдсан байгаа. Усны нөөцийг хуримтлуулах, ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Онги, Цагаанбургастайн төслийн бэлэн байдлыг хангах гэсэн ажил тусгагдсан байгаа.

Энэ ажилд 3.9 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр. Гол хэрэгжүүлэгч нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Усны газар хамтран хэрэгжүүлэхээр байгаа.

Одоогийн явцын хувьд хувьд Орхон, Цагаанбургастайн төслийн хүрээнд Онги, Улааннуур, Тавантолгойн ус дамжуулах байгууламжийн ТЭЗҮ, техникийн зураг төслийн ажлыг 2022 он, 2023 онд хийж гүйцэтгэсэн байдалтай байгаа.

Хийж гүйцэтгэсэн компани нь “Гидродизайн инновац” гэдэг ийм компани байгаа.

Гол бидний хувьд хийгдэхээр төлөвлөж байгаа ажил бол нэгдүгээрт төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдэнэ. Ажлын нарийвчилсан зураг төслийг хийнэ. Төсвийг хийнэ гэдэг ийм ажил тусгагдсан байна.

Мэдээж таны хэлж байгаачлан гол үр дүн бол говийн бүсийн аймгуудыг усан хангамжийг сайжруулахтай холбоотой ажил тусгагдсан байгаа.

Ер нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас энэ ажлыг санаачилдаггүй ч байдаг юм уу, эсвэл үүнийг улсын хөгжлийн төлөвлөгөөнд оруулахаар өгдөггүй ийм асуудлууд огт байдаггүй. Бид ногоон хөгжлийн бодлогын төлөвлөлтийн гол баримт бичиг дээр 3 гол энэ томоохон хөрөнгө оруулалтын ажлыг байнга санал болгож өгдөг.

Нэгдүгээрт, Төсвийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбогддуулаад 1 дүгээрт хасагдсан.

Сүүлийн жилүүдэд төсвийг оновчтой зохион байгуулна гэдэг энэ агуулгаар хасагдаад явж байгаа.

Хоёрдугаарт, сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой асуудал дээр бид мэдээж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, тэр дундаа энэ “Ногоон хөгжлийн бодлого”-той уялдаатайгаар Эрчим хүчний яамнаас эрчим хүчний шилжилттэй холбоотой тодорхой бодлогуудыг нэлээн сайн авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа гэж ингэж үзэж байгаа.

Сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн хүрээнд гэхэд манай Байгаль орчин, аялал жуулчлалын яаман дээр гэхэд одоогийн байдлаар Монгол, Японы хамтарсан кредит тооцох механизмын хүрээнд 11 төсөл хэрэгжиж байна.

Түүнээс 6 нь хэрэгжсэн байдалтай явж байгаа.

Энэ төслүүдийн хувьд нэгдүгээрт нэгэнт хөрөнгө оруулалт хийчихсэн төслүүдийн хүрээнд хэвийн үйл ажиллагаагаа цаашид ханган ажиллахад хүндрэлтэй байдлууд үүсэж байгаа.

Нэгдүгээрт, эцсийн хэрэглэгчийн үнэ тарифтай холбоотой асуудал үүсдэг.

Хоёрдугаарт, холболттой холбоотой тарифуудын асуудлууд үүсдэг. Энэ дээр мэдээж нөгөө салбаруудын уялдаа холбоо л хангагдах шаардлагатай байгаа гэж ингэж харж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Т.Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Т.Энхтүвшин: Тэгээд жоохон санаачилгатай ажилламаар байна. Байгаль орчны яам.

Бас нэг барьсан ажлаа дуусгадаг, хэрэгжүүлдэг гээд нэг ийм тал руугаа явахгүй бол тэгээд энэ асуудал чинь их удаан яваад байна шүү.

Орхон-Онгийн асуудал бол би сая Онгийг урсаж байгаа байдал дээр нь, газар дээр нь очоод үзлээ л дээ. Техник, эдийн засгийн үнэлгээ нь хийчихсэн 50-аас, 70 тэрбум төгрөг л байх юм бол энэ асуудлыг шийдчих юм билээ шүү дээ.

Тэгээд яагаад энэ дээр ажиллахгүй байгаа юм. Та хэд. Энэ асуудал дээрээ

бэлэн байгаа. Одоо Дундговь аймаг дээр урсаад ирсэн юмыг Өмнөговь аймаг руу шилж урсгачихад бололцоо боломж нь байгаа юм билээ шүү дээ.

Тэгээд энэ асуудал дээр үнэхээр санаачилга муутай ажиллаж байна. Үнэхээр харамсаж байгаа шүү. Байгаль орчны яаманд.

Сая ер нь их олон хүн, 6 мянга гаруй иргэнтэй уулзлаа. Үнэхээр Байгаль орчны яам ажлаа хийхгүй байна. Юун тэрбум модны асуудал вэ, юун газар тариалан бэ, юун хөнгөн үйлдвэрлэл барьж арьс ширний үйлдвэр байгуулах асуудал. /минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт тавьж, хариулт авч дууслаа. Саналтай гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

Ч.Ундрам гишүүнээр тасаллаа. Ч.Ундрам гишүүн саналаа хэлье. Ч.Ундрам гишүүний микрофоныг нээе.

Ч.Ундрам: Энэ 2025 оны Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөнд нэлээн чухал асуудлууд туссан байна гэж үзэж байна.

Сая миний хувьд энэ төвийн бүсийн 54 сум, суурин газруудаараа бүгдээр нь орж тойроод ард иргэдтэйгээ уулзаад ирлээ.

Тэгээд сумдын, тосгодын хамгийн чухал асуудал бол ерөөсөө энэ дэд бүтцийн асуудал байна. Зам харгуй байж тариа будаагаа, сүү саалиа тээвэрлэнэ. Тэгээд эрчим хүчний асуудал.

Тэгээд миний хүсэлт болгосон асуудлууд бүгдээрээ төлөвлөгөөнд туссанд маш их баяртай байна.

Жишээлэх юм бол Баруунбүрэн-Орхонтуул, Орхонтуул-Цээл чиглэлийн авто зам ирэх жилийн төлөвлөгөөнд орсон байна.

Баруунбүрэнгийн Амарбаясгалант хийд чиглэлийн авто зам бас орсон байна.

Энэ бол тухайн бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд маш чухал.

Батсүмбэрээс цаашаа Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгоны авто замын асуудал орсон байна. Лүнгийн чиглэлийн авто замыг 4 эгнээ болгоно гээд.

Тэгэхээр ер нь ийм чухал чухал дэд бүтцийн асуудлуудыг энэ төлөвлөгөөнд суулгаж өгнө гэдэг нь ирэх жилийн төсөвт яг энэ ажлыг хийж хэрэгжүүлэх шаардлагатай санхүүжилтүүд нь бүгд яг сууна гэсэн үг.

Тэгээд энэ төлөвлөгөөг нэлээн нарийн судалгаатай, тойрог бүсийн гишүүдийн саналыг авч боловсруулсанд маш их баяртай байна.

Тэгээд дэмжиж байна.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Бид жилийнхээ төлөвлөгөөг батлахад одоо ингээд бид үзэл баримтлалын хувьд дэмжих, дэмжихгүйгээр ингээд хэлэлцэх эсэхийг нь ингээд дэмжээд явчихвал ажлын хэсэг байгуулна. Угаасаа.

Тэгэхээр ажлын хэсэг байгуулж байж ажиллах учраас манай гишүүд ажлын хэсэгт орж ажиллах ёстой.

Ер нь нэлээн гишүүд маань санал бодолтой байгаа байх.

Яагаад гэвэл дараагийн жил хийх ажлууд, амласан амлалтууд нь их юм тавигдсан байгаа байх.

Тэгээд манай гишүүд их баяртай байгаа юм байна. Зарим нь тавьсан юмнууд нь.

Тэгэхдээ Засгийн газраасаа бас нэг асуучихъя даа.

Ер нь дараагийнхаа Их Хурал нь одоо ингээд төсвөө батлах юм чинь гээд ингээд тавьчихсан юм уу?

Үнэхээр их тийм сайн боломж байна уу? Гэрэл гэгээтэй байгаа юм уу?

Энэ дээрээ яах вэ, Та нар өөдрөг тавьчихсан бол угаасаа ажлынхаа хэсэг дээр бид бүгдээрээ сайн ярилцъя.

Ажлын хэсэг гарч ажиллах учраас ингээд санал хураалтаа явуулъя. Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 61.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг уншиж танилцуулна.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа. /алх цохив/

Ажлын хэсгийнхэн баярлалаа. Та бүхэн гарч болно.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудлуудын сүүлчийн асуудал.

Дөрөв.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Сүүлчийн хэлэлцэх асуудал нь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр танилцуулна.

Б.Энхбаяр сайдын микрофоныг нээе.

Б.Энхбаяр: Байнгын хорооны эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 86-д “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах” гэж заасныг үндэслэн тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан танилцуулж байна.

Улсын Их Хурлаас 1995 онд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийг батлан мөрдүүлсэн бөгөөд эдийн засаг, бизнесийн хурдацтай хөгжиж байгаа өнөөгийн орчин нөхцөлд тус танхим зохицон ажиллах, аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлөх чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа нь энэхүү хуулийг боловсронгуй болгох практик шаардлагыг бий болгож байна.

Хуулийн төслийг дээрх үндэслэл шаардлага болон олон улсын сайн туршлагыг харгалзан Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан бөгөөд хуулийн төсөлд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүтэц, тогтолцоог сайжруулах, чиг үүргийг шинээр тодорхойлох, төрийн шийдвэр гаргах ажиллагаанд бизнес эрхлэгчдийн оролцоог хангахтай холбоотой зохицуулалтыг тусгасан болно.

Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчныг сайжруулах, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг төлөөлөн

илэрхийлэх, хамгаалах зорилгыг хэрэгжүүлэх бөгөөд Монголын Үндэсний танхим, аймаг, нийслэлийн болон салбарын танхим, гадаад улс дахь төлөөлөгчийн газраас бүрдэхээр тусгалаа.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад оролцох, бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг төрийн холбогдох байгууллага, албан тушаалтанд төлөөлөн илэрхийлэх, хамгаалах, тэдгээрийн үйл ажиллагаа, шийдвэрийн үр нөлөөг сайжруулахтай холбоотой санал, зөвлөмж хүргүүлэх болон зөвлөл, хороо, комисс, ажлын хэсэг зэрэг хамтын удирдлагын бүрэлдэхүүнд төлөөлөх төлөөлөл оролцуулах замаар аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль, ёсны сонирхлыг хамгаалахаар тусгалаа.

Аймаг, нийслэлийн танхимын тухайд тухайн аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 50-иас доошгүй тооны аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулахаар, харин салбарын танхимыг эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарт үйл ажиллагаа явуулж байгаа, мөн тооны аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулахаар тусгаж, үйл ажиллагаагаа бие даан хэрэгжүүлэхээр заасан.

Түүнчлэн аймаг, нийслэлийн болон салбарын танхимууд нь Монголын үндэсний танхимын гишүүн байх ба харин аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь Монголын Үндэсний танхимд гишүүнээр элсэхгүй бөгөөд өөрийн үйл ажиллагаа явуулж буй эдийн

засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарын танхим, эсхүл аймаг, нийслэлийн өөрийн харьяа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах аймаг, нийслэлийн танхимд сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэх замаар Монголын үндэсний танхимын үйл ажиллагаанд оролцохоор боловсрууллаа.

Мөн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын санхүүгийн бие даасан байдлыг хангах хүрээнд Монголын үндэсний танхимын үзүүлэх үйлчилгээ болох гарал үүсэл тодорхойлох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл хүнд нөхцөл байдлыг гэрчлэх бараа тээврийн хэрэгслийг түр хугацаагаар нэвтрүүлэх баримт бичиг олгох, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлчилгээ болон арбитр эвлэрүүлэн зуучлал зэрэг үйлчилгээний хөлсний хэмжээг Монголын үндэсний танхимын Удирдах зөвлөл тогтоохоор тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бие даасан байдлыг хангах, аж ахуй эрхлэгчдийн эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг хамгаалах, төр, хувийн хэвшлийг хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нөхцөл боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Иймд хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Б.Энхбаяр сайдад баярлалаа.

Ингээд ажлын хэсэг танилцуулъя. Б.Энхбаяр Хууль зүй, дотоод хэргийн сайд, Г.Эрдэнэбулган Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон

гүйцэтгэгч байгаа юм уу? Н.Жамьянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга, Д.Энхтүвшин Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч, Д.Ончинсүрэн Улаанбаатар хотын Худалдааны танхимын Ерөнхийлөгч. Д.Ончинсүрэн алга уу? Б.Хаш-Эрдэнэ Улаанбаатар хотын Худалдааны танхимын гүйцэтгэх захирал, Т.Дүүрэн Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын гүйцэтгэх захирал Ж.Оюунчимэг Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын Бодлого, стратегийн газрын дарга, С.Энхцэцэг Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын дарга, М.Шинэбаяр Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Л.Пүрэвсүрэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Л.Загдаа Өмгөөллийн “Хэруга Партнерс” ХХН-ын гүйцэтгэх захирал, өмгөөлөгч.

Ингээд хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулттай гишүүд байна уу? Нэрсээ өгөөрэй.

Т.Энхтүвшин гишүүнээр тасаллаа.
Х.Ганхуяг гишүүн нэмчих.

Х.Ганхуяг гишүүнээр тасаллаа.
М.Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хуулийг төслийн хувьд дэмжиж байгаа.

Энэ бол өмнө нь орж ирээд тэгээд бас буцаад татаад авчихсан шүү дээ. Тийм ээ.

Хоёр ч хууль яваад байгаа. Нэг нь, Мэргэжлийн холбоодын хууль гээд. Хэлэлцэх эсэх нь дэмжигдчихсэн.

Одоо энэ Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль орж ирж байна л даа.

Аливаа улс орны Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь улс орныхоо яг эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд, гадаад хөрөнгө оруулалтыг татахад, дотоодын чөлөөт зах зээлийн өрсөлдөөнийг бодитоор хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Манайд Худалдаа, аж үйлдвэрийн танхим олон жилийн хугацаанд яг энэ үүргээ гүйцэтгэж ирж чадаагүй. Та нар маань ч өөрсдөө мэдэж байгаа. Тийм ээ.

Өнөөдөр манай ихэнх улс орны эдийн засгийн тулгуур салбаруудад монопол дэндүү их болчихоод байгаа. Монополчиллол. Тийм ээ. Сая гурилын үнэ дээр юу болсон. Сая эмийн сонголт дээр та нар харсан байх. Бас л монопол. Хэдхэн компани энэ зах зээлийг базсанаас болоод зах зээл эрүүлээр хөгжиж чадахгүй сөрөг үр дагаврууд их гараад байна.

Яг үүн шиг зөндөө зүйлүүд байгаад байна л даа.

Тэгэхээр одоо энэ хуулийг бид дэмжээд явлаа гэхэд энэ хууль дээр тэр саяын зах зээлийн монополчлолыг задлах, чөлөөт зах зээлийг дэмжих, жижгүүд нь том руугаа орох, том нь дэлхийн зах зээл рүү гарах чиглэл дээр Худалдаа, аж үйлдвэрийн танхим ийм

байна, энэ дээр ийм оролцоотой байна гэсэн тийм яг тодорхой заалтууд орж ирж байгаа юу? Нэгд энэ асуулт байна.

Хоёрт нь, санхүүжилтийн механизмыг өөрчлөхгүй бол болохгүй болж байгаа гэж байна. Мэдээж яг энэ санхүүжилт нь бас олон улсын жишгээр байж Худалдаа, аж үйлдвэрийн танхим жинхэнэ утгаараа хөгжих байх. Тийм ээ. Тэгэхгүй бол одоо энэ хэдхэн том компаниасаа. Өмнө нь яг тийм байсан шүү дээ. Нэлээд тийм юу авчихдаг. Дотаци авдаг. Тэгээд түүнийхээ төлөөсөнд нь Худалдаа, аж үйлдвэрийн танхим тэр компаниа бараг дэмжсэн бодлого явуулдаг байсан.

Би эдийн засгийн чиглэлээр яг сэтгүүлч хүн байсны хувьд үүнийг маш сайн мэднэ л дээ.

Тэгэхээр одоо энэ санхүүжилтийн хувьд та нар үүнийг ингэж олон улсын жишигт яг ийм арга замаар хүргэснээр бид бие даасан байдлаа хадгалж чадна гэдгийг жишээ нь ямар заалтаар оруулж байгаа вэ гэсэн хоёр асуулт байна. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 2 номер хариулах уу? Хэн хариулах юм? Ажлын хэсгээс хэу хариулах юм? Ажлын хэсгийн 2 номер. Битгий дараарай. Хүлээж байгаарай. Ажлын хэсгийн 2 номерын микрофоныг нээе.

Д.Энхтүвшин: М.Оюунчимэг гишүүний асуултад баярлалаа. Та зөв хэллээ.

Ер нь хувийн хэвшил эдийн засгийн хөгжлийн гол хөшүүрэг, гол хөдөлгөгч хүч нь байдаг. Бусад улсууд ч гэсэн энэ хувийн хэвшлээ тодорхой хэмжээний бүтэц, зохион байгуулалтад

оруулж байж бодлогоо төрийн бодлоготой уялдуулж ажилладаг.

Тэгэхээр систем, бүтэц нь Худалдаа, аж үйлдвэрийн танхим гэдэг бүтцээр явдаг. Тэгээд энэ дээр мэдээж улс орны онцлогуудаас хамаараад өөр өөр бүтцүүд явдаг.

Энэ дээр нийтлэг бусад орнууд дээр тавьдаг юм бол “заавал гишүүнчлэлтэй” гэдэг асуудал яригддаг. Өөрөөр хэлбэл саяын таны яриад байдаг цөөн хэдэн салбарын түрүүлж зах зээлд орсон компаниуд бодлогоо давамгайлдаг. Энэ байдлаас гарахын тулд уг нь том жижиггүй ингээд бүгдийг нь оруулах үүднээс “заавал гишүүнчлэлтэй” гэдэг заалтуудыг оруулдаг.

Одоо жишээлбэл Герман, Австрали, Япон, Солонгос эд нар бол бүгдээрээ заавал гишүүнчлэлтэй гэдэг ийм санал байдаг.

Тэгээд бид хэд яах вэ, санаа бол заавал гишүүнчлэлтэй байвал жижгүүд нь ч гэсэн бас ороод, тэгээд нөгөө том компаниудын тоогоороо цөөхөн учраас энэ үйл ажиллагаан дээр ингэж явах юм болов уу гэсэн тийм бодолтой байсан.

Гэхдээ хуулийн төсөл дээр яг энэ заалт бас ороогүй байгаа. Өмнө нь зарим гишүүдээс энэ нөхцөл байдалд бэлэн биш байна гээд байгаа.

Тэгээд энэ дээр болохоор 50-иас дээш аж ахуйн нэгжүүд хуралдаж байж тухайн эдийн засгийн салбарын ч юм уу, эсвэл аймаг, нийслэлийн танхимыг байгуулахаар заасан байгаа.

Дээр нь Хууль зүйн яамнаас бас нэг оруулсан санал бол нэг эцсийн өмчлөгчтэй компаниудын тоог

хязгаарлаж өгөхөөр заалтууд оруулсан байгаа.

Тэгэхээр энэ тоо болон тэр эцсийн өмчлөлтэй холбоотой хязгаарлалтууд нь цөөн хэдэн компани салбарын монопол компаниуд өөрийн бодлогоо хэрэгжүүлэхээс, эсвэл салбарын нийтлэг эрх ашгийг илэрхийлэхгүй байх эрсдэлээс хамгаалж байгаа ийм хоёр төрлийн заалтууд байгаа.

Тэгээд салбарын танхимууд байгуулагдаж, үндэсний танхимын хэмжээнд бизнесийн нийтлэг эрх ашгийн асуудлууд яригдана.

Тэгэхээр салбар салбарын асуудлуудаа тэртээ тэргүй бие даасан үйл ажиллагаа явуулж байгаа энэ холбоодууд нь юм уу, эсвэл энэ танхимууд нь хамгаалаад явна.

Үндэсний танхим дээр бол илүү нийтлэг эрх ашгууд яригдах учраас зөвхөн нэг компани гэхээсээ илүү одоогийн тооцооллоор бараг 40, 50 танхим байгуулагдахаар байгаа.

Тэгэхээр өөр өөр салбарууд ярьж байгаа учраас нэг компани, нэг том компани, нэг групп компани илүү дуу хоолойтой байх боломжгүй болж байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: М.Оюунчимэг гишүүн хариулт хангалттай юу?

Ажлын хэсгийн 1 номероос нэмж хариулах юм байна. 1 номерыг нэе. 1 номерын микрофоныг нээ дээ. Хариулаарай.

Д.Ончинсүрэн: Саяын монопол гэдэгтэй холбоотойгоор би хариулт хэлье гэж бодож байна л даа.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын зорилго хоёр л юм байгаа юм.

Ерөнхийдөө бизнес эрхлэх орчныг нь тогтвортой, эрүүл байлгах талаар бодлого боловсруулж, бодлогыг хамгаалж, өмгөөлж оролцох.

Хоёрт нь, ерөнхийдөө эдийн засагт хувийн секторыг илүү оролцуулах, илүү хувийн оролцоотой эдийн засгийг хөгжүүлэх тэр чиглэлийн бодлогыг боловсруулж, хамгаалж, өмгөөлж оролцох ийм л хоёр үндсэн үүрэгтэйгээр байгуулагдаж байгаа.

Түүнээс биш монопол компанийг бий болгохгүй, монополын эсрэг ажиллана гэж байгуулагдахгүй.

Энэ Монополын тухай хууль гэж бас байгаа. Тэгээд тэр бол төрийн бодлого, зохицуулалтаар монополын асуудал байгаа бол тэрийг ерөнхийдөө хуулиараа шийдэх ёстой.

Зүгээр ер нь монопол гэж юу юм бэ гэхээр тодорхой салбарт ганц компани байхыг л монопол гэж хэлээд байгаа. Тийм ээ. Тэгээд түүгээрээ ашиг орлого, үнийг өөрөө тогтоож чаддаг, хүссэн үнийг тогтоож чаддаг. Түүгээрээ хамгийн ашигтай ажиллахыг хэлээд байгаа юм.

Хэрвээ Монгол компаниудыг бүгдийг нь гаргаж ирж байгаад тийм их ашиг олоод, ингээд “bottom line”³-ыг нь очиж хараад үзээд тэгээд ганцаараа үнэ тогтоогоод байгаа юм уу гэх юм бол тийм юм байхгүй л байгаа байх гэж бодож байна.

³ “bottom line” - цэвэр ашиг буюу бүх зардлыг хассаны дараах цэвэр орлого.

Тэгэхээр энэ дээр яг анхаарч бид ярих ёстой юм болов уу гэж бодож байна. Монопол байдаг уу, байдаггүй гэдэг дээр.

Тэгээд тэр бол өөр тусдаа хуулиар зохицуулах ёстой асуудал.

Ц.Цэрэнпунцаг: Нэмж асуух уу? М.Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

М.Оюунчимэг: Энэ хууль дээрээ ер нь жоохон тодотгоод хэлэлцүүлгийн явцад оруулж өгөх нь зөв байх шүү. Д.Энхтүвшин дарга аа.

Тэгэхгүй бол үнэхээр нэг компанид биш нэг, хоёр нь нийлж байгаад л монополчлоод байна шүү дээ.

Авч байгаа зээл, тусламжаас өгсүүлээд. Тийм ээ. Сая үүнийг жишээ нь гурилан дээр маш тодорхой харлаа шүү дээ.

Тэгэхээр үүнийг бид бас задалж өгөхгүй бол энэ хууль тэрийг дагаад бас Монополын тухай хууль юм уу, эсвэл бусад хуулиуд өөрчлөгдөнө шүү дээ. Хэрвээ энэ хууль батлагдаад гарвал.

Тэгэхээр дагалдах хуультайгаа хэлэлцүүлгийн явцад зохицуулалтуудыг хийж өгөх нь дахиад л энэ өөрчлөгдөөд байхгүй, урт хугацаанд Монгол Улсын бизнесийн салбар, хувийн хэвшил, төр, хувийн хэвшлийн түншлэл зөв замаараа хөгжөөд явахад хэрэгтэй гэдэг үүднээс ярьж байгаа юм шүү. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: М.Оюунчимэг гишүүн санал хэлэх шиг боллоо. Тийм ээ. М.Оюунчимэг гишүүний саналыг Та бүхэн бас. Ажлын хэсэг. Одоо угаасаа ингээд бид хэлэлцэх хэсэг нь дэмжигдээд явбал ажлын хэсэг гарна шүү дээ. Ажлын хэсэг дээр ороод та нар гишүүдийнхээ

ярьж байгаа, сануулж байгаа, асууж байгаа асуудлуудыг сайхан тусгаж, хичээж ажиллана шүү.

Ч.Ундрам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрам: Энэ Худалдаа, аж үйлдвэрийн танхимын эрх зүйн байдлын тухай хууль нэлээн хүлээлттэй хууль байгаа.

Өмнө нь Х.Ганхуяг гишүүний хамт өргөн бариад, тэгээд тэр маань бас хэлэлцэх эсэх нь шийдэгдээгүй.

Тэгээд одоо ингээд Засгаас орж ирж байгаад баяртай байна.

Тэгээд энэ танхимыг нэлээн идэвхтэй, төр, засгийн аливаа шийдвэрт дуу хоолойгоо нэгтгээд хүргэж байгаасай гэж би боддог юм.

Тэр ч утгаараа сая 2024 оны Монголбанкны мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн ажлын хэсгийн ахлагчаар ажиллахдаа танхимынхантай очиж хэлэлцүүлэг хийсэн.

Тэгээд энэ бол одоо анх удаа л мөнгөний бодлогын асуудлаар, банкны асуудлаар танхимтай хамтарч хэлэлцүүлэг хийсэн ийм тохиолдол байсан гэж надад хэлсэн.

Тэгээд цаашид илүү ойрхон, аливаа хууль, ялангуяа энэ бизнестэй холбоотой хуулийг хэлэлцүүлэхдээ бид энэ танхимын тодорхой төлөөллүүдтэй бас ярилцаж байх нь зөв юм болов уу гэж боддог юм.

Тэгээд яах вэ, зарим хуулийг ярьж байхад нэг салбар мөртөө аягүй олон холбоод гарч ирээд байдаг байхгүй юу. Тэгээд хоорондоо зарим нь таардаггүй.

Үзэл бодол нь ч гэсэн зөрчилдөөд, хоорондоо бүр ерөөсөө нэг танхимд ч сууж чадахгүй тийм байгууллагууд байдаг.

Эдгээр бизнесүүдийг яаж нэгтгэх ёстой юм бэ?

Одоо бас Мэргэжлийн холбоодын эрх зүйн байдлын тухай хууль ч билүү, нэг тийм хууль орж ирээд хэлэлцэх эсэх нь шийдэгдчихсэн явж байгаа.

Тэгэхээр одоо энэ хоёр хууль чинь яаж хоорондоо холбоотой байх юм?

Энэ хуулийн төсөл дээр 4.5, 4.6-д аймаг, нийслэл болон салбар ингээд нэг нэг л танхимтай байна гээд заачихсан байна.

Тэгэхдээ энэ зарим жижиг аймагт чинь 50 аж ахуйн нэгж ер нь байхгүй ч аймаг байдаг шүү дээ. Жижигхэн аймгууд. Бага хүн амтай.

Тэгэхээр үүнийг яаж зохицуулах юм бэ гээд ийм асуулт байна.

Хоёрдугаарт, их сургуулийн удирдлагаар ажиллаж байхад төлөөлөн удирдах зөвлөлд бизнес эрхлэгчид болон төгсөгчдийн төлөөлөл гээд орж ирдэг байсан л даа.

Тэгсэн мөртөө эдгээр хүмүүс маань нөгөө боловсон хүчин манайд хомсдолтой байна. Ирж байгаа хүмүүс нь бид нарт хэрэгтэй юмыг хийж чадахгүй байна, мэдэхгүй байна гээд л яриад байдаг мөртөө Удирдах зөвлөлд орж ирчхээд яг тэр асуудлыг ерөөсөө ярьдаггүй.

Тэгэхээр уг нь энэ мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, их

сургуулиудын ТУЗ-д яг ямар боловсон хүчин бид нарт хэрэгтэй байгаа юм бэ гэдгээ хэлээд, илэрхийлээд яг түүн дээр нь хамтарч ажиллаад явж байдаг хүмүүс байвал их зүгээр байгаа юм.

Тэгээд яах вэ, энэ дагалдаж байгаа хууль дээр нь Мэргэжлийн боловсролын тухай хуулийн удирдах зөвлөлд энэ танхимаас төлөөлөн орно гэж байгаад би баяртай байна.

Нэмээд их сургуулийн бас Удирдах зөвлөлд оруулмаар байна.

Улсын хүрээлэнгүүд байдаг. Судалгааны энд бас оруулмаар байгаа байхгүй юу. Бизнес, шинжлэх ухаан хоёрыг ойртуулж байж бид инновац, шинэ бүтээгдэхүүнүүд бий болгоно.

Тэгэхээр ийм зүйлүүд дээр Та хэд маань ямар бодолтой байгаа юм? Мэдээж цаашид ажлын хэсэг байгуулагдаад ажиллахаар би бас орж ажиллах хүсэлтэй байна. Ажлын хэсэгт. Ялангуяа энэ боловсон хүчин тал дээр, боловсролын тал дээр нэлээн санаа зовдог хүний хувьд тийм бодолтой байна.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Ундрам гишүүний асуусан асуултад ажлын хэсгийн 2 номероос хариулъя. 2 номерын микрофоныг нээе.

Д.Энхтүвшин: Ч.Ундрам гишүүнд баярлалаа.

Тэгээд гол асуудал байгаа. Өнгөрсөн хугацаанд 70, 80 мянган төрийн бус байгууллагууд бий болчихсон. Тэгээд бизнесын салбар дээр ч гэсэн яг энэ харилцаанууд байгаа. Зарим төрийн бус байгууллагууд нь цөөн хүмүүсийн, хэсэг бүлгийн эрх ашгийг ч юм уу, эсвэл ганц нэг хүмүүсийн эрх

ашгийг хамгаалдаг ийм байгууллагууд бас байгаа нь нэгдэж нийлэх ч юм уу, энэ дээр асуудалтай байгаа.

Тэгэхээр энэ танхимын хуулийн бас нэг зорилго нь эдийн засгийн салбаруудын дуу хоолойг нэгтгэх, татварын хувьд ч гэсэн, ажиллах хүний нөөцийн хувьд ч гэсэн гол салбараа төлөөлж байгаа энэ төрийн бус байгууллагуудыг нь илүү ач холбогдол өгч, тэд нартайгаа илүү ажиллаж, төрийн байгууллагуудын зүгээс ч гэсэн яг эд нартайгаа илүү ажилладаг болгоё гэсэн ийм санаа байгаа.

Тэгэхээр аажмаар, хүчээр биш нөлөөллөөрөө нэг байгууллага дээрээ илүү төвлөрөх, эсвэл нийтлэг эрх ашгийг нь илүү төрийн бодлогод оруулах ийм бололцоо боломжууд нээгдэх юм уу гэж бодож байна.

Хөдөө, орон нутгийнхнаас санал асуухад зарим аймгууд дээр дангаараа танхим байгуулагдахгүй байх магадлалууд, аймаг дундын танхим байгуулагдах магадлалууд бас байгаа.

Тэгэхээр үүнийг хууль дээр ийм бололцоог нь нээгээд тавьсан байгаа.

Яах вэ, бидний хийсэн судалгаагаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа хамгийн цөөн аж ахуйн нэгжтэй Говьсүмбэр аймаг 200 гаруй аж ахуйн нэгжтэй ийм дүр зураг байгаа. Тэгэхдээ энэ нь яах вэ, боломжуудыг нь нээсэн.

Дээр нь хоорондоо уялдаж ажиллах боломжуудыг аймаг дундын, эсвэл салбар дундын танхим байгуулагдах боломжийг нээсэн байгаа.

Бид бас хүний нөөцтэй холбоотой асуудал дээр бид нарт хуучин хандлага гэх юм уу даа, хүний нөөцийг жишээлбэл улс бэлдэж өгдөг байсан. Яг энэ хандлага нэлээн яваад байгаа. Сүүлийн үед тохиолдож байгаа энэ хүний нөөцийн хомсдол бас яг энэ дээр өөрөөр харах бололцоо боломжуудыг өгч байгаа гэж бодож байгаа.

Тэгээд үүнтэй холбоотойгоор ер нь ажил олгогч нар буюу компаниуд өөрсдөө хүний нөөцөө бэлдэх дээр нэлээн идэвхтэй оролцох ёстой юм байна гээд.

Сая өнгөрсөн онд батлагдсан Боловсролын хуулийн үзэл баримтлалын хүрээнд мэргэжлийн болон техникийн хосмог сургалт дээр аж ахуйн нэгжүүдийг нэлээн идэвхтэй оролцдог, танхимын сургалтаас гадна ихэнх сургалт хөтөлбөрийг шууд зах зээлтэй нь, аж ахуйн нэгжтэй нь уялдах талаар хосмог сургалтын энэ системийг Монголд нутагшуулах талаар танхим боловсролын яамтай хамтраад ажиллаж байгаа. **GZ** Gesellschaft für Internationale Zusammenarbeit, ГЭЭД Германы хамтын ажиллагааны байгууллагатай бас эхний хэд хэдэн мэргэжлийн энэ хосмог сургалтыг бий болгох талаар ажиллаж байна.

Тэгээд үүнтэй холбоотойгоор хуулийн төсөл маань оны сүүлээр гарсан. Тэгээд шинээр хосмогтой холбоотой.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 2 номероос гүйцээгээд хариулчихъя.

Д.Энхтүвшин: Тэгээд хосмогтой холбоотой заалт маань танхимын хууль дээр ерөөсөө орж чадаагүй байгаа.

Үүнийг ажлын хэсэг дээр ч юм уу оруулбал зүгээр юм уу гэсэн бодолтой байгаа.

Дээр нь шинжлэх ухааны байгууллагуудтай, ер нь Монголын экспортын гол бүтээгдэхүүнүүдийн хувьд яг “ноу-хау”, инновац шингэсэн байхгүй бол өрсөлдөх чадварын хувьд бас асуудалтай байгаа.

Тэгэхээр энэ чиглэлээр судалгааны байгууллагууд, эрдэм шинжилгээ, ялангуяа их сургуулийн дэргэдэх судалгааны байгууллагуудтай нэлээн ажиллая. Лабораторийн тоног төхөөрөмжийг нь илүү үр бүтээлтэй ашиглая. Судалгааны чиглэлийг нь аж ахуйд чиглэсэн, бизнестээ чиглэсэн болгоё гэдэг талаар нэлээн ойрхон ажиллаж байгаа.

Одоо их сургуулийн удирдах зөвлөлд танхимын төлөөлөл гээд, аж ахуйн нэгжийн төлөөлөл гээд 2 хүн орж байгаа. Бараг энэ долоо хоногт эхний Удирдах зөвлөлийн хурал болох гэж байгаа.

Дээр нь бусад судалгааны байгууллагуудын бүтцэд нь орж ажиллах талаар нэлээн ойрхон ажиллахаар ярьж байгаа.

Тэгээд зарим аж ахуйн нэгжүүдийн хувьд их сургуулийн дэргэдэх лабораториудтай хамтарч ажиллаад эхний туршилтууд, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлт дээр ажиллаад эхэлж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Т.Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа.

Би танай хуулийг дэмжиж байгаа. Зүгээр хоёрхон асуулт өөрсдөөс чинь асуугаад үздэг юм уу гээд.

Хөдөлмөрийн хуульд өөрчлөлт орсон. Ялангуяа уул уурхайн компаниуд 14, 14 хоног болсон. Тийм ээ. Үүнийг ер нь та хэд маань дэмждэг юм уу, дэмждэггүй юм уу?

Амьдрал дээр яваад үзэхэд нэгдүгээрт жижиг уурхайд маш их хүндрэлтэй байна. Цалин хөлс нь буурсан. Дээр нь хүн хүчний хомсдолд орсон гээд.

Энэ дээр та хэд ямар бодолтой байдаг юм бэ?

Сая би Өмнөговь аймагт очоод 2, 3 уурхайтай уулзлаа. Тэгээд ярьдаг асуудал үүнийг л ярьж байна. Энэ 14, 14 чинь ерөөсөө амьдралд нийцэхгүй байна. Ерөөсөө энэ Хөдөлмөрийн хуулиа өөрчилж өгөөч ээ гэдэг асуудал тавьж байна. Эдийн засгийн хувьд ч гэсэн аягүй хохиролтой болчхож байгаа байхгүй юу.

200 хүн ажиллаж байсан уурхай 300 хүн ажилладаг болсон. 2 мянган хүн ажилладаг уурхай чинь 3 мянган хүнтэй болсон. Цалин буурсан. Тэгээд 14 хоног амраад яаж байна гэхээр өөр ажил хайгаад явж байна шүү дээ. Яг үнэнийг хэлэхэд. Өөр ажил хайгаад.

Энэ дээр Худалдаа, аж үйлдвэрийн танхим бас дуу хоолойгоо гаргаасай гэж бодож байна. Энэ дээр ер нь ямар бодолтой байдаг юм?

Яах вэ, Их Хурлын гишүүд бид яг уулзаад л явж байна л даа. Үүнийг өөрчилье гэдэг дээр. Тэгээд танхим өөрөө ямар бодолтой байгаа юм? Танхим судалгаа хийсэн зүйл байдаг уу,

байдаггүй юм уу гэдэг дээр. Энэ дээр нэг ийм асуулт асуучихъя.

Хоёрдугаар асуудал. Бид энэ уул уурхайн бүтээгдэхүүнээ баяжуулъя, боловсруулъя гээд л. Олон хүнийг ажлын байраар хангая. Өндөр цалинтай болгоё гээд л яриад байгаа.

Тэгээд энэ АМНАТ-ын асуудал дээр онцгой анхаарахгүй бол болохгүй нь. АМНАТ-ын асуудал дээр. Бас нэг хуулийг нь өргөн барьчхаад Их Хурал дээр л яваад л байгаа л даа.

АМНАТ гэдэг бол газар ухаж байгаа компани. Уул уурхайн компани АМНАТ, нэмэгдсэн өртгийн албан татвараа төлөх ёстой.

Баяжуулж байгаа, боловсруулж байгаа уул уурхайгүй компани АМНАТ-тай үнээ нэмэгдсэн өртгийн албан татвартай, баяжмалаа, хүдрээ авч байгаа.

Тэгээд энэ давхар АМНАТ төлөөд байна.

Тэгээд цаашдаа Монгол Улсад энэ баяжуулах болон боловсруулах үйлдвэр баригдахгүй байна.

Тэгээд намайг Засаг даргаар ажилладаг байхад Эрээн дээр ерөөсөө боловсруулах баяжуулах, үйлдвэр байдаггүй байсан. Одоо 7 үйлдвэр тэнд ажиллаж байна.

Хүхрийн хүчлээс нь салгахаас эхлүүлээд, угаахаас нь эхлүүлээд, кокс болгохоос нь эхлүүлээд.

Танхим энэ дээр бас нэг санаачилгатай ажиллаач ээ. Танхим аж ахуйн нэгж, байгууллагуудаа төлөөлөөд дуу хоолойгоо гаргах ёстой. Ялангуяа

Монгол Улсад ажлын байрыг нэмэгдүүлэх, эцсийн шатад боловсруулах энэ тал дээр нэлээн дуу хоолой гаргаж, судалгаа шинжилгээтэй ажиллах болов уу л гэж бодоод байгаа юм.

Ийм асуудал дээр бид ажиллах хэрэгтэй байна.

Гурав дахь асуудал. Улсын Их Хурал дээр маш олон хууль тогтоомжууд гарч байгаа.

Гурав дахь нь зүгээр санал шүү.

Ямар зүйл гарч байна вэ гэхээр ерөөсөө энэ хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэл, бүх төрлийн тоног төхөөрөмжийг импортын татвараас чөлөөлсөн. Чөлөөлсөн.

Энэ доод шатдаа аж ахуйн нэгж, байгууллага, бизнес хийх гэж байгаа, жижиг, дунд үйлдвэрлэл хийх гэж байгаа хүмүүс мэдээ мэдээлэл маш муу байна. Маш муу байна.

Тэгээд та хэд энэ дээр жоохон идэвхтэй ажиллаад, тэр аймаг, орон нутагт байж байгаа Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг аймаг, сумын Засаг даргатайгаа нийлээд ч гэдэг юм уу энэ сурталчлах, таниулах ажлыг хийж өгөөч ээ.

Би аймгийн Засаг дарга, Тамгын газрын даргаар ажиллаж байсан учир аймгийн Худалдаа, аж үйлдвэрийн танхим юу хийдгийг би мэднэ.

Ц.Цэрэнпунцаг: Т.Энхтүвшин гишүүний асуултад 2 номер хариулах уу? Ажлын хэсгийн 2 номерыг нээе.

Д.Энхтүвшин: Т.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Чухал асуудлууд хөндөж байна. Хөдөлмөрийн хууль дээр хэлэлцүүлэг нэлээн эрчтэй хийсэн. Аж ахуйн нэгж, байгууллагууд ч гэсэн өөрийнхөө саналыг хэлсэн.

Тэгээд гурван талт, одоо жишээлбэл Үйлдвэрчний эвлэл тодорхой хэмжээгээр, тал талууд оролцож явсан.

Гэхдээ Их Хурал дээр яг хэлэлцүүлгийн явцад анх ярилцсан, зөвшилцсөн ойлголтоосоо нэлээн өөр тийшээ явчихсан.

Тэгээд яах вэ, энэ дээр бүх компаниудын хувьд хууль хэрэгжих зарчим, өөрөөр хэлбэл амьдралд мөрдөгдөхгүй болохоор энэ асуудал маань ихэнх жижиг аж ахуйн нэгжүүдийн хувьд үүнийг мөрдөх ямар ч бололцоогүй байна гэдэг шаардлагуудаа тавьж байгаа.

Тэгээд танхимын зүгээс энэ чиглэлээр саналуудаа өгч байгаа. Тэгээд үүнийг өглөө гээд бидний хувьд бас яг ний нуугүй хэлэхэд бизнесийн байгууллагуудын хувьд нэгдэж нийлэхгүй учраас дуу хоолой нь ер нь ингээд тарсан байдалтай, сул байдалтай. Зөндөө л олон хурал, уулзалтууд хийдэг. Тэгээд яг үр дүнд нөлөөлөх хэмжээнд байж чадахгүй байгаа.

Тэгээд энэ дээр аж ахуйн нэгжүүдийн ярьж байгаа асуудал сүүлийн үед татвартай холбоотой, нийгмийн даатгалтай холбоотой, Хөдөлмөрийн хуультай холбоотой энэ асуудлууд яригдаж байгаа.

Тэгээд энэ Хөдөлмөрийн хууль нь одоо хүний нөөцийн хөдөлмөрийн зах зээлийн хомсдолтой байдалтай давхар уялдаад ирэхээр хүн олдохгүй байхад

дээр нь саяын хуулийн зохицуулалтаар ажлын байр, орон тоо нэмэх хэрэгцээ гарч байгаа.

Тэгэхээр энэ нь зах зээлийн бодит байдал дээрээ нийцэхгүй байгаа учраас энэ дээр бид эсрэг. Энэ хуулийг өөрчлүүлье гэсэн тийм хүсэл сонирхолтой байгаа.

Тэгэхээр энэ нь өөрөө нөгөө хууль засагладаг зарчим руугаа, хууль нь илүү амьдрал дээр хэрэгждэг байх зарчим руугаа явах ёстой. Энэ чиглэлээр бид үргэлжлүүлж дуу хоолойгоо өргөнө гэсэн бодолтой байгаа.

АМНАТ-ын хувьд ч гэсэн энэ дээр бас яг нийтлэг асуудал болохоор хуулийн зарим зүйл, заалтууд нь тодорхой бус ч юм уу, эсвэл өөр ойлгогдохоор байгаа байдал нь энэ АМНАТ дээр жишээ гарч ирж байгаа.

АМНАТ-ыг бусад энэ хуулийг хэрэгжүүлэх байгууллагуудын хувьд тайлбарлаж байгаа. Тэр зах зээлийн үнэ, борлуулалтын үнэ гэдгийг жишээлбэл яаж тооцох вэ гэдэг нөгөө ойлголтууд нь тодорхой заагаагүйгээсээ болоод өөр өөрөөр тайлбарлаад.

Тэгээд сүүлдээ та бүхний өргөн барьж байгаа хуулийн хэлэлцүүлгийн талаар бас сонссон л доо.

Тэгэхээр манай татварын систем маань өөрөө эдийн засгийн хөгжүүлдэг хэрэгсэл биш, илүү төсөв бүрдүүлэх хэрэгсэл болохоор энэ утгаараа хандахаар энэ одоо жишээлбэл тодорхой хэмжээнд авах ёстой зүйл гэдэг ерөнхий байдлаар тайлбарлаад байгаа нь зохистой биш санагдсан. /минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Тодруулж асууя. Гүйцээж хариулах юм уу? Хангалтгүй байна. Хангалтгүй гэж үзсэн учраас. Тэгвэл гүйцээж хариулъя. 2 номероос.

Д.Энхтүвшин: Тийм. Тэгээд энэ хуулийг илүү тодорхой тайлбарладаг, анх хуулийн үзэл баримтлалын түвшнээсээ авхуулаад яг хэлэлцэгдэх процесс хүртэл нь нэг жигд байдаг байх ёстой юм уу гэсэн.

Энэ тал дээр хувийн хэвшил нэгдсэн байр сууриа жишээлбэл танхимын хууль батлагдаад ирвэл энэ талаар нэлээн идэвхтэй байр суурь илэрхийлье гэж бодож байна.

Тэр боловсруулах үйлдвэр дээр ер нь бидний хувьд нэмж нүүрс олборлохгүйгээр, эсвэл нэмж мал нядлахгүйгээр илүү орлого олох бололцоо боломж байхад үүнийгээ бас ашиглах нь зүйтэй.

Энэ хэмжээгээр нөгөө өрсөлдөх чадварууд нэмэгдэж байгаа учраас илүү боловсруулах, илүү “ноу-хау”, шинжлэх ухаан шингэсэн энэ чиглэлийн юмнууд явах талаар дэмжинэ гэсэн байр суурьтай байгаа.

Тэгээд гурав дахь нь санал байсан. Тийм ээ. Саналыг хүлээж авлаа.

Ц.Цэрэнпунцаг: Тэг ээ.., танд нэмэлт цаг байгаа. Нэмэлт асуулт асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа.

Та бүхэн энэ дээр саналаа өгөөд явбал бидэнд илүү хэрэгтэй байгаа юм гэдгийг хэлмээр байна.

Ер нь аймаг, орон нутагт ажиллаж байхад бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудыг жоохон төвлөрүүлээд цуглуулдаг хүмүүс бол манай Худалдаа, аж үйлдвэрийн танхим л даа. Энэ дээрээ та хэд Улсын Их Хурлаас гаргасан хууль тогтоомжийг л.

Ялангуяа энэ бизнес, аж ахуйн нэгж, байгууллага руу чиглэсэн энэ зүйлийг л нэг сурталчлах, таниулах ажил дээр хамтарч сайн ажиллаасай л гэж хүсэж байна. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Х.Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Би хууль санаачлагчаас нэг асуулт. Тэгээд танхимд хоёр санал хэлэх юм.

Нэгдүгээрт, хууль санаачлагчаас ямар асуулт асуух гээд байна гэхээр Хөдөлмөрийн хууль. Сая Т.Энхтүвшин гишүүний яриад байгаа Хөдөлмөрийн хууль байдаг юм уу, нийгмийн даатгалын, одоо ингээд гурван талт хэлэлцээрүүд байгаа.

“Ажил олгогч”, “ажилтан”, “Засгийн газар” гээд.

Тэгээд “ажил олгогч” дээр нь болохоор нэг хүн 34 жил хувийн хэвшлийг төлөөлж гарын үсэг зурж ирсэн.

Тэгээд үүнээсээ болоод дандаа Нийгмийн даатгалын хууль, Нийгмийн даатгалын сан дээр төвлөрсөн мөнгийг янз янзын банк дээр байршуулаа гэж гардаг асуудлууд.

Хөдөлмөрийн хуулийн буруу зөрүү боллоо гэдэг асуудлууд. Дандаа ингэж дутуу дулимаг хийгдэх. Хувийн

хэвшлийн оролцоог нь дутуу хангаснаасаа болоод.

Тэгэхээр яах вэ? бид энэ угаасаа шинэчилсэн найруулга юм чинь тэр асуултыг тэр оролцогчийг солих асуудлыг би ярих гээд байгаа юм. Тэгээд тэнхимийг ажил олгогчоор нь солих боломж байгаа эсэх? Яагаад гэхээр Засгийн газраас үүнийг нь санаачилж болохгүй юм байна лээ.

Энэ угаасаа шинэчилсэн найруулга юм чинь тэр асуудлыг, тэр оролцогчийг солих асуудлыг би ярих гээд байгаа юм.

Тэгээд танхимыг ажил олгогчоор нь солих боломж байгаа эсэх. Яагаад гэхээр Засгийн газраас үүнийг санаачилж болохгүй юм билээ.

Тэгэхээр бид энэ хэлэлцэх эсэх дээрээ авч гарсныхаа дараа анхны хэлэлцүүлгийн үед ажлын хэсэг ажиллаад тэр асуудлыг хөндөж болох эсэхийг асуух юм.

Хоёрдугаар асуудал. Санал болохоор танхимд. Маш сайн хуулийн багтай болмоор байна.

Яагаад гэхээр хувийн хэвшлийг төлөөлж 4 жил янз янзаар үзлээ, янз янзаар л балбууллаа. Яах вэ, одоо ингээд зүгээр жишээ дуудахад **“Малчны нийгмийн даатгал”** гээд.

Би ганцаараа эсэргүүцээд яриад байсан боловч гэхдээ тэр чинь эргээгээд хэнд нөлөөлдөг вэ гэхээр төлж байгаа хүмүүсийн эрх ашиг нь дандаа хөндөгддөг байхгүй юу.

Нэг ёсондоо хувийн хэвшил болон хувийн хэвшилд ажиллаж байгаа

хүмүүсийн эрх ашиг нь хөндөгдөж байгаа байхгүй юу.

Яагаад гэхээр тэр татвар нь буурахгүй л гэсэн үг. Яагаад гэхээр нийгмийн даатгалын шимтгэл нь буурахгүй л гэсэн үг байхгүй юу.

Тэгээд яах ийм юм дээр танхим маш хурдтайгаар, шаардлагатай бол тэр эсэргүүцлээ илэрхийлдэг, бас өөрсдийнхөө хүрч чадах гишүүд болон Засгийн газрын гишүүдэд хандаж тиймэрхүү буруу юм хийгдвэл бас ингэж ярьдаг болмоор байна.

Зөвхөн Улсын Их Хурлын гишүүдийг хараад суугаад баймааргүй байна.

Олон асуудал орж ирсэн шүү. Ер нь хувийн хэвшлийн эрх ашиг хөндөгдөж байгаа, татвартай ч холбоотой.

Хүн амын орлого нь л албан татвар 10 саяас дээш орлоготой бол одоо ингээд татвараа нэмэгдүүлсэн асуудал ч орж ирсэн. Тэр мэр чинь уг нь бид иргэнээ баян болгох л зорилготой байгаа шүү дээ.

Тэгсэн мөртөө орлого нь нэмэгдэнгүүт л татварыг нь нэмээд л байдаг. Тийм ээ. Төлж байгаа хүмүүсийнх нь татвар нь улам нэмэгдээд л байдаг. Жоохон буруу юм руугаа яваад байгаа байхгүй юу. Хоёрдугаар асуудал.

Гуравдугаар асуудал. Зөвшөөрлийн хууль гээд.

Уг нь бид чинь аль болох л нөгөө хүнд суртлын багасгах, авлигалыг багасгах, зөвшөөрлийг багасгах.

Тэгээд тэр Зөвшөөрлийн хуулийн манаач нь уг нь танхим байхгүй юу. Яагаад гэхээр та нарыг бид тэнд зөвшөөрлийн зөвлөлд оруулсан байхгүй юу.

Тэгээд одоо Х.Ганхуяг дуугарахгүй л бол зөвшөөрөл дээр хэн ч дуугарахаа больчихсон.

Уг нь тэр Засгийн газар дээр Ерөнхий сайдын дэргэд та нар энэ зөвшөөрөлтэй холбоотой янз янзын асуудал байвал хажуугаас нь чихэн дээр нь ингээд хонх уяад явдаг баймаар байна л даа.

Одоо ингээд сая яаралтай горимоор орж ирсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль дээр тэр витаминь зөвшөөрлийг нь бүртгэл болгоод л бүртгэл нь зөвшөөрлийн шинж чадвартай болоод л ороод ирж байгаа байхгүй юу.

Өнөөдөр Байнгын хороон дээр би М.Оюунчимэг гишүүн, бусад гишүүдийг гуйгаад л гуйгаад л дийлсэнгүй.

Сая М.Оюунчимэг гишүүн тэр Эмийн түр хороон дээр яасан. Яам бол зүгээр мафи шүү дээ. Ер нь бол. Зөвшөөрлийг нь байхгүй болгочхож байхад ингээд гүрийсээр байгаад л тэгээд л яг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль өргөн барихдаа тэнд нь “зөвшөөрөл” гэдэг үгийг нь “бүртгэл” гээд л оруулчхаж байгаа байхгүй юу.

Тэгээд би одоо ингээд нэг хуулийн манаач хийдэг ийм ажилтай л болчихоод байна л даа. Тийм. Үгүй үгүй. Харин дэмжиж байсан гэдгийг л хэлж байна л даа.

Тэгэхээр цаашдаа энэ зөвшөөрөлтэй холбоотой асуудлууд дээр.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Хариулт. Ажлын хэсгийн. Б.Энхбаяр сайд хариулья.

Б.Энхбаяр: Х.Ганхуяг гишүүнтэй санал нэг байна.

Ер нь яах вэ, одоо ингээд парламентын гишүүд тодорхой хуультай нэр холбогдож явдаг л даа.

Үнэхээр энэ дээр манлайлал үзүүлж, түүнтэйгээ холбогдож түүнийхээ хойноос санаа чилээж явдаг Х.Ганхуяг гишүүний гол хийсэн хууль бол энэ Зөвшөөрлийн хууль.

Би Засгийн газрын гишүүнээр томилогдоод энэ хууль бол үнэхээр их чухал, ард иргэдэд хүндрэл учруулж байсан олон асуудлыг цэгцэлсэн байна.

Тэгээд үүнийг илүү цааш нь үргэлжлүүлж хийх ажил зөндөө байгаа юм байна гэдэг дээр нэлээн сайн мэдэрч ажиллаад байгаа. Тийм.

Одоо жишээлбэл Хууль зүйн сайд 160 орчим журам баталсан байдаг юм байна. Үүнийхээ 87-г нь хүчингүй болгож байгаа. Нийтдээ одоо бараг мянгаад журмыг шууд урж хаях ёстой юм билээ.

Ер нь одоо ингээд хуулиас зугтаад дандаа ийм журмаар хүнд суртал, бүр үнэн нь тогтоогдсон, хүний эрхэд халддаг, бүр хүн шийтгэж байна шүү дээ.

Саяын энэ жолоочийн торгуулийн оноо гэхэд чинь Хууль зүйн сайд 2015 онд баталчихсан журмаар л хүнийг шийтгээд байгаа байхгүй юу.

Тэгээд хүний эрхэд халддаг гээд. Ингээд хальчихсан юм билээ. Тэгээд энэ дээр танхимтай үнэхээр хамтарч ажиллах ёстой.

Х.Ганхуяг гишүүн бол заавал дахиж сонгогдох ёстой. Энэ хуулиа үргэлжлүүлж манах ёстой юм билээ.

Би ингээд манаад байна гэдэг нь үнэн юм билээ.

Энэ чинь өөрөө хийсэн хүн энэ хуулийнхаа араас манаж байхгүй л бол ерөөсөө тэгээд л хулгай болох юм билээ.

Тийм учраас би Х.Ганхуяг гишүүнийг Баянголчууд заавал сонгох ёстой гэж бас хэлмээр байна.

Хоёрдугаарт, Ажил олгогч эздийн холбоо гээд ер нь энэ яах вэ, холбоо, сангийн хууль буюу энэ төрийн бус байгууллагуудын хуулийг цэгцлэхгүй бол таны асууж байгаа Ажил олгогч эздийн холбооны Х.Ганбаатар шиг 34 жил ажил олгогчдын нэрээр өмчлөөд, тэгээд төртэй харьцаад Нийгмийн даатгалын сангаас янз бүрийн ажил олгогчдод зориулсан сургалт гэнэ үү, жил болгон хэдэн зуун саяар нь мөнгө аваад сурчихсан ийм юмнууд зөндөө байгаа.

Тэгээд үүнийг цэгцлэх ёстой.

Тийм учраас энэ танхим шиг хуультай, олон нийтийн бүх төлөөллийг дотоод ардчиллаа бий болгосон энэ бүтэцтэйгээ төр нь хамтрах ёстой юм билээ.

Түүнээс биш нэрийг нь ашигласан ийм нэг хүний өмч болчихсон, өв залгамжлуулах маягтай болчихсон ийм юмнуудыг ер нь болих ёстой юм билээ.

Тэгээд энэ хүмүүс ч гэсэн одоо жоохон ичих хэрэгтэй. Одоо болих хэрэгтэй.

Тийм ч учраас Үйлдвэрчний эвлэлийн хуулийг би яаман дээрээ буцаагаад байгаа... /минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт асууж дууслаа.

Би нэг тодорхой асуулт асуучихъя. Тодорхой ч юу байх вэ. Сая Та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Мэргэжлийн нэгдсэн холбооны хууль гарсан шүү дээ.

Тэгээд энэ хуультайгаа та нар энэ ажлын хэсэгт оролцсон улсууд нь давхцаж байгаа юу? Ер нь яаж уялдуулж холбогдсон юм? Хэн хариулах вэ? Дөнгөж саяхан гарсан.

Одоо тэгээд давхцаад, тэгээд энэ хуультай яаж уялдаж холбогдож байгааг нь нэг тодорхой хэлээдхээрэй. Ажлын хэсгийн 2 номер хариулья.

Л.Загдаа: Асуултад хариулья.

Мэргэжлийн нэгдсэн холбооны тухай хуулийг харахаар мэргэжлийн холбоогоо төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн гээд байгуулах субъектүүд нь нээлттэй байгаа.

Танхимын хувьд төрийн бус байгууллагын хэлбэртэй. Салбарын болон аймаг, нийслэлийн танхим. Байгуулах этгээдүүд нь аж ахуйн нэгжүүд байгуулж явах юм.

Хоёрдугаарт, танхимын тухай хуулиар худалдаа, үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой өөр бусад үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус

байгууллагын харилцаанд ерөөсөө оролцохгүй. Тус тусынхаа чиг үүргийг хэрэгжүүлээд явна.

Зөрчилдөж байгаа зүйл байхгүй. Харин хамтраад явах тийм боломжууд нь нээлттэй. Илүү энэ танхимын тухай хуулийн тэр салбарын танхимын чиг үүргийг шилжүүлэх гэх мэт зохицуулалт дээр илүү нийцэлтэй тийм хууль болсон байна гэж ажлын хэсгийнхэн харж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Хамгийн гол нь тийм ярьж байгаа бол сайн л байна. Тэгээд л сайн тэр мэрийг нь хооронд нь давхцаж мавхацсан юм.

Тэгээд дөнгөж саяхан нэг хуулиа бид чинь. Б.Баттөмөр гишүүн ахалж ажилласан. Тийм ээ. Нэлээн их ажил болж байж үүнийгээ бараг л дахиж шинэчилж бараг л бичихтээ тулж байж нэг ийм хууль гаргасан шүү дээ.

Тэгээд л үүнийгээ буцаад л дахиад л танхимын хууль хэлэлцэх эсэх нь яваад л, ингээд л ажлын хэсэг гараад ажиллаад ингээд батлахад дахиад л буцаад л дөнгөж сарын өмнө батлагдсан хуулиа дахиад л баахан дагуулж орж ирээд л өөрчлөлт оруулаад байх юм байна уу, үгүй юу гэдэг дээр сайн анхаарч ажиллаарай. Та бүхэн.

Тэгээд Их Хурлаас гарч байгаа хуулиуд маань бас чанар чансаатай юм байх хэрэгтэй шүү дээ.

Ингээд л түрүүчийнхээ гарч байгаа хуулиудад уялдаа холбоо бий шүү. Хамгийн гол нь энэ чинь бид мэргэжлийнхээ холбоодыг эдийн засгийн үр өгөөжтэй тэр мэргэжлээ, нэг талдаа бизнес хийдэг тэр талаараа нэгдэж, ашиг сонирхолд нь нийцэж байгаа

холбоонуудаа бид чинь ялгаж аваад л Мэргэжлийн нэгдсэн холбооныхоо хуулиар зохицуулж байгаа учраас энэ гарцаа байхгүй танхимын хуульд анхаарч ажиллах хэрэгтэй.

Одоо яах вэ, бүр гарцаа байхгүй уялдаа холбоотой бид түүнийгээ дагуулаад хооронд нь нийцлэл гаргахаар юм байх юм бол тэгээд бас эртхэнээс анхаараад нэг харчхаарай. Ажлын хэсэг дээрээ сайн анхаараарай.

Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалт явуулж эхэлье.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 53.8 хувийг нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Зөвшөөрлийн хуулийн манаач Х.Ганхуяг гишүүн танилцуулна.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлэг үүгээр дууслаа. /алх цохив/

Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Та бүхэнд чуулгын нэгдсэн хуралдаанд амжилт хүсье.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Бас ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Хуралдаан 1 цаг 51 минут үргэлжилж, 16 цаг 51 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД